



ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ



Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

АРБИТРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ЗАХИАЛАГЧ: ХУУЛЬ ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

САНХҮҮЖҮҮЛЭГЧ: ГЕРМАНЫ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА

Улаанбаатар хот
2024 он

СУДАЛГАА ГҮЙЦЭТГЭСЭН:

М. Уянга, Хууль зүйн ухааны доктор, МУИС, ХЗС-ийн дэд профессор
Б.Нинжин, Хууль зүйн ухааны доктор, МУИС, ХЗС-ийн ахлах багш

ГАРЧИГ

УДИРТГАЛ	4
1.1 Үнэлгээ хийх үндэслэл	5
1.2 Үнэлгээ хийх хүрээ	5
1.3 Үнэлгээний шалгуур үзүүлэлт	6
1.4 Үнэлгээний арга зүй	6
ХОЁР. ХЭРЭГЖИЛТИЙН ҮЕ ШАТ	8
2.1 Олон улсын арбитрын тухай загвар хууль ба үндэсний хууль тогтоомж	8
2.2 Арбитрын тухай хуулийн зохион байгуулалтын хэрэгжилт, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж буй арбитрын байгууллагууд	16
Дүгнэлт, зөвлөмж	19
2.3 Байнгын арбитрын үйл ажиллагаа, зохицуулалт, практик	20
2.4 Арбитр ба шүүхийн оролцоо	27
2.5 Арбитрчийн мэргэжлийн ур чадвар ба ёс зүйн асуудал	30
2.6 Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхтэй холбоотой асуудал	34
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	36
3.1 Арбитрын тухай хууль олон улсын загвар дүрэмд нийцсэн эсэх	36
3.2 Байнгын арбитр болон байнгын бус арбитраар хэрэг хянан шийдвэрлүүлсэн байдал	36
3.3 Арбитрын үйл ажиллагааны зохицуулалтын, хэрэгжилт, дүрэм олон улсын жишигт нийцсэн .. байдал:	37
3.4 Арбитрын үйл ажиллагаа дахь шүүхийн оролцоог хязгаарлаж, зохицуулах	37
3.5 Арбитрын мэргэжлийн ур чадвар, ёс зүй, сонирхлын зөрчлөөс хамгаалах зохицуулалт	38
3.6. Арбитрын шийдвэр биелүүлэх талаар	38
Нэгдсэн санал, зөвлөмж	39
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	40
ХАВСРАЛТ	41
Хавсралт 1. Хүснэгт 1. UNCITRAL Загвар хууль ба Монгол Улсын Арбитрын тухай хуулийн .. харьцуулалт	41
Хавсралт 2. Шүүхийн Ерөнхий Зөвлөл “Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн дотоодын болон гадаадын арбитрын ажиллагаанд оролцсон мэдээлэл”	45
Хавсралт 3. Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын мэдээлэл	46
Хавсралт 4. МҮХАҮТ-ын дэргэдэх Олон улсын арбитраар хянан шийдвэрлэсэн хэргийн мэдээлэл	47

УДИРТГАЛ

Монгол Улс дахь арбитрын үйл ажиллагааг зохицуулж буй Арбитрын тухай хууль / шинэчилсэн найруулга/ 2017 онд батлагдсан байдаг. Энэхүү хууль нь өмнө нь үйлчилж байсан 2003 оны Арбитрын тухай хуулийг өөрчилж, Олон улсын худалдааны комисс-оос боловсруулсан Арбитрын загвар хуульд үндэслэгдэн боловсруулагдсан юм. Уг хууль хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөж эхэлснээс хойш Монгол Улсад МҮХАҮТ-ын дэргэдэх Олон улсын арбитраас гадна хэд хэдэн байнгын арбитрын байгууллага байгуулагдаад ажиллаж байна. ШЕЗ-ийн арбитрын хэргийн талаар судалгааг үндэслэхэд тус хууль батлагдсанаас хойш 550 орчим хэрэг арбитрын байгууллагаар шийдвэрлэгдсэн байв. Иргэний шүүхээр хянан шийдвэрлэж буй тоотой харьцуулахад арбитраар маргаанаа шийдвэрлүүлж байгаа нь харьцангуй бага хэвээр байна.

Иймд энэхүү 2017 оны Арбитрын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт 2015 онд батлагдсан Хууль тогтоомжийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр “Аргачлал батлах тухай” тогтоолын 6 дугаар хавсралтад заасан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-ын дагуу үнэлгээг Хууль зүй дотоод хэргийн яамны захиалгаар хийж гүйцэтгэлээ.

Хууль тогтоомжийн тухай хуулиар Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийдэг бөгөөд шаардлагатай тохиолдолд үүнээс өмнө ч хийнэ. Харин үнэлгээг хийхдээ тухайн хуулийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хуульд бүхэлд нь эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно гэж заасан байдаг.

“Арбитрын тухай хууль”-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгаа нь хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, зорилгодоо хүрсэн байдал, гарсан ахиц дэвшил болон хэрэгжүүлэхэд гарсан бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг тогтоож, анхаарах асуудал, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой бөгөөд хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шатаас бүрдсэн болно.

Судлагдсан байдал: Арбитрын тухай хууль, түүний мөн чанар, ач холбогдлын талаар хэд хэдэн судалгаа хийгдсэн байна. Эрдэмтэн судлаачид, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэг, олон улсын байгууллага болон Хууль зүй дотоод хэргийн яамны захиалгаар бие даасан болон судалгааны хүрээлэнгийн зарим судлаач, оюутнууд арбитрын үйл ажиллагаатай холбоотой судалгааг хийжээ. Эдгээр судалгааны ажлуудаас нийтэд нээлттэй болсон зарим ажлыг танилцуулбал:

1. Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах Ажлын тайлан (Арбитрын тухай), 2010 он
2. “Арбитрын тухай хуулийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл, эрх зүйн орчныг сайжруулах арга зам” судалгааны ажлын тайлан, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2011 он
3. “Монгол Улс дахь арбитрын байгууллага, түүхэн товчоон 1930-2020 он, Арбитрын 90-н жилийн ойн хүрээнд гарсан судалгаа,” МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон улсын арбитр, 2020 он
4. Арбитрын сэдэвт эрдэм шинжилгээний нийтлэлийн эмхэтгэл, МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон улсын арбитр, 2020 он

2017 оны Арбитрын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн энэхүү судалгааны ажил нь бусад судалгааны бүтээлээс дараах зорилго болон судалгааны хүрээгээр ялгагдаж байна. Үүнд:

1. Хуулийн зорилт биелэгдсэн байдал, хэрэгжилтийн асуудалд үнэлгээ өгөх,
2. Олон улсын жишиг стандарт, ЮНСИТРАЛ-ын загвар хууль болон журамд нийцсэн байдал,
3. Монгол Улс дахь Арбитрын ажиллагааг хэрэгжүүлж буй байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ,
4. Арбитрын үйл ажиллагааны тулгамдсан болон цаашид анхаарах асуудлыг тодорхойлох,
5. Байнгын арбитрын байгууллагуудын хэрэг хянан шийдвэрлэх дүрэмд үнэлгээ өгч, хэрэгжилтийн үр дагаврыг нь тодорхойлох,
6. Арбитрын үйл ажиллагааг олон улсын улсын жишиг стандартад нийцүүлэх тухай хуулийн зорилго хэрхэн хэрэгжиж байгаад үнэлгээ өгөхийг судалгааны үндсэн зорилго болгосон.

Өмнө нь энэ чиглэлээр хийгдсэн судалгаа дараах хүрээнд хийгдсэн байв. Үүнд:

1. Арбитрын тухай хуулийг бусад хууль, эрх зүйн бусад акттай харьцуулж, давхардал хийдийг судлах зөрчлийг арилгах, 2010 онд
2. Байнгын арбитрын талаар гадаад орнуудын судалгаа, 2011 он
3. Арбитрын үйл ажиллагаа дахь шүүхийн оролцоо, гадаад орны холбогдох хуулийн судалгаа

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1 Үнэлгээ хийх үндэслэл

“Хууль тогтоомжийн тухай” хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “... хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийнэ” гэсэн. Энэхүү үндэслэл, шаардлагын хүрээнд ХЗДХЯ-аас ирүүлсэн захиалгын дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуульд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээг хийж, гүйцэтгэлээ.

Монгол Улсын Арбитрын тухай хууль /цаашид “АтХ” гэх/ нь 2017 оны 1 дугаар сарын 26-нд шинэчлэгдэн батлагдсан бөгөөд хэрэгжиж эхэлснээс хойш 5 жилийн хугацаа өнгөрчээ. Энэ хугацаанд тус хуулийн хэрэгжилтийн эерэг болон сөрөг үр дагаврын талаар судалгаа хийгдээгүй байна.

2017 оны нэмэлт өөрчлөлт нь Арбитрын тухай хуулийг Нэгдсэн Үндэсний Байгууллагын Худалдааны комиссоос баталсан ЮНСИТРАЛ-ын загвар хуульд нийцүүлэх зорилготой байсан. НҮБ-ын Олон улсын худалдааны комиссоос баталсан Олон улсын арилжааны арбитрын тухай ЮНСИТРАЛ-ын Загвар хууль нь 1986 онд батлагдаж, 2010 онд нэмэлт өөрчлөлт орж байсан.

Энэхүү загвар хууль нь олон улсын арбитрын үйл ажиллагааны онцлог болон хэрэгцээнд үндэслэсэн дэлхийн нийтээр ашиглагдаж болох арбитрын үйл ажиллагааны үндэсний зохицуулалтыг бий болгоход нь туслах зорилготой юм. ЮНСИТРАЛ-ын Загвар хуульд арбитрын үйл ажиллагааны бүхий л үе шат, арбитрын ажиллагааг эхлүүлэх, арбитрын хэргийн харьяалал, арбитрчийг томилох, шүүхийн оролцоо, хэрэг хянан шийдвэрлэх, арбитрын шийдвэр, түүнийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх талаар зохицуулсан байдаг. Дэлхийн орнуудын эрх зүйн зохицуулалтын онцлог, эдийн засгийн харилцааг харгалзан зохицуулсан байдгаараа энэхүү загварын хуулийн онцлог юм. ЮНСИТРАЛ-ын загвар хуулийн дагуу Арбитрын тухай хуулийг боловсруулсан улс нь олон улсын жишигт нийцүүлэн арбитрын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гадаад болон дотоодын иргэн, хуулийн этгээдэд олон улсын стандартын дагуу бизнесийн маргааныг хянан шийдвэрлүүлэх, шийдвэрийг биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Монгол Улс Арбитрын тухай хуулийг энэхүү загварт нийцүүлэн батлаад 7 жил болох гэж байгаа ч Арбитрын байгууллагад хандаж маргаанаа хянан шийдвэрлүүлж буй тоо хэрэг, дотоодын шүүхэд хэрэг шийдвэрлүүлж байгаатай харьцуулахад бага байгаа бөгөөд үүний улмаас шүүхийн ачаалал их үзүүлэлттэй хэвээр байна. Мөн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арбитрын байгууллагуудад ихэвчлэн дотоодын маргаан шийдвэрлэж байгаа нь хуулийн хэрэгжилт, тулгарч буй бэрхшээлд судалгаа хийх шаардлагыг бий болгож байна.

Монгол Улс нь гадаад эдийн засгийн харилцаанд идэвхтэй оролцож байгаа энэ үед гадаад хэлцэл, бизнесийн харилцаанаас үүдэлтэй маргааныг арбитраар шийдвэрлүүлэх байдлыг нэмэгдүүлэх болон шүүхийн ачааллыг бууруулах зорилгоор энэ хуулийн хэрэгжилтэд үнэлээ өгч, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор энэхүү судалгааг хийх хэрэгцээ шаардлагыг зүй ёсоор бий болгож байгаа юм.

1.2 Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “Үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” хэмээн заасныг удирдлага болгов. Улмаар Арбитрын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх хүрээг дараах байдлаар тогтоолоо.

1. Арбитрын тухай хууль нь (2017) ЮНСИТРАЛ-ын загвар хуультай нийцсэн байдал
2. Байнгын болон байнгын бус арбитрын үйл ажиллагааны хэрэгжилт
3. Монгол Улс дахь байнгын арбитрын байгууллагын дүрэм, хуульд нийцсэн байдал
4. Арбитрын үйл ажиллагаа дахь шүүхийн оролцоо, тулгамдсан асуудал
5. Арбитрчийн мэргэжлийн үр чадвар, ёс зүйн асуудал
6. Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх асуудал

1.3 Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Арбитрын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхдээ аргачлалын 3.4-д заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийг бодитойгоор илэрхийлж чадах шалгуур үзүүлэлтийг харгалзан сонгов. Шалгуур үзүүлэлтүүдээс:

“Зорилгод хүрсэн түвшин” болон “Практикт нийцэж байгаа байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг түлхүү хэрэглэж, хуулийн үнэлэх зүйл, заалтын хэрэгжилтийг шалгаж чадах, тэдгээрийг хэмжих боломжтой гэдэг байдлаар тохируулж сонгов. Шалгуур үзүүлэлтүүдийг сонгохдоо АтХ-ийн 1-р зүйлд тусгасан “Энэ хуулийн зорилт нь эрх зүйн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх ажиллагаатай холбоотой харилцааг олон улсын стандартад нийцүүлэн зохицуулахад оршино” гэсний дагуу хуулийн зохицуулалтыг бүлэглэн олон улсын стандартад нийцсэн эсэхийг үнэлэх шаардлагыг үндэслэлээ. Мөн “практикт нийцэж байгаа” эсэх шалгуурыг хэрэгжүүлэхдээ “Үнэлгээ хийх хүрээ”-нд заасан бүлгүүдэд хуваарилан АтХ дахь нэр томьёоны тодорхой бус байдал, арбитрын харьяалал, тусгайлсан арбитрын зохицуулалт, арбитрын шийдвэрийн биелэлт болон бусад тулгамдсан асуудлыг үнэлнэ. Зарим хэсэгт хэрэгжилтийн байдлыг тодорхойлох зорилгоор “хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг” мөн шалгуур болгосон.

1.4 Үнэлгээний арга зүй

Арбитрын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ харьцуулсан арга зүй ашиглан

- ЮНСИТРАЛ-ын загвар хууль, нэмэлт өөрчлөлттэй нийцэж буй эсэх,
- Байнгын арбитрын дүрэм нь олон улсын загвар дүрэм болон Арбитрын тухай хуультай нийцсэн эсэхийг үнэлсэн.

Мөн судалгаанд мэдээлэл цуглуулах арга ашиглан үнэлгээ хийх шаардлага, үнэлгээний хүрээ, тогтоосон шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр зэргээс хамаарч тоон болон чанарын мэдээллийг ашиглаж дараах судалгааг гүйцэтгэсэн. Үүнд:

- **Баримт бичгийн судалгаа:** АтХ-ийн талаар хийгдсэн болон бусад судалгааны тайлан, холбогдох статистик, тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Судалгааг хийхдээ Олон улсын загвар хууль, дүрэм, байнгын арбитрын дүрэм, журам, өмнө нь хийгдсэн судалгаа болон бусад дотоодын хууль тогтоомж ба бусад ач холбогдол бүхий баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийлээ. Үүнд:
 - ЮНСИТРАЛ-ын Арбитрын загвар хууль
 - ЮНСИТРАЛ-ын Арбитрын загвар дүрэм, тайлбар
 - Гадаадын зарим улсын Арбитрын тухай хууль
 - Арбитрын тухай хуулийн хэрэгжилт, үр нөлөөний талаар судалгааны тайлан
 - Арбитрын тухай хууль
 - Барилгын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм
 - Спортын арбитрын дүрэм
 - Улаанбаатар хотын арбитрын дүрэм
 - МХАҮТ-ын арбитрын дүрэм
 - Бусад холбогдох дүрэм журам
 - Статистик, тоон мэдээллийн лавлагаа
- **Фокус ярилцлага:** АтХ-ийн хэрэгжилтийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, арбитрын байгууллага, судлаач, арбитрч, мэдээлэл судалгаа хийдэг байгууллага, Шүүхийн ерөнхий зөвлөл, ШШГеГ, Нийслэлийн анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгчээс ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан. Уг хүрээнд ажиллагаанд хуульд заасны дагуу оролцож буй төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагын албан хаагчаас ярилцлагын аргаар анхан болон нэмэлт мэдээлэл, тодруулга, тайлбар авах бичил судалгааны удирдамж боловсруулж, түүний дагуу мэдээллийг цуглуулав. Ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулахдаа дараах асуудлыг судалж, цуглуулсан:
 - Арбитрын харьяалалтай холбоотой маргаан;
 - Арбитрын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл
 - Арбитрын үйл ажиллагаатай гаргаж буй гомдол
 - Арбитрын шийдвэрийг давж заалдаж буй гомдол

- Арбитрын хууль дүрмийн хэрэгжилт
- Бусад хуулийн уялдаа, нийцэл, бэрхшээл
- Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо

2017 оноос хойш Арбитрын байгууллагуудад хянан шийдвэрлэсэн хэрэг, анхан шатны болон давж заалдах шатны шүүхэд арбитрын ажиллагаатай холбоотой гомдол болон өргөдөл шийдвэрлэсэн байдал, арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэхтэй холбоотой статистик, тоон мэдээллийг үндэслэж үнэлгээ хийхэд ашигласан.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргын дагуу хэрэгжилтийн үе шатыг хийж гүйцэтгэв. Ингэхдээ холбогдох байгууллагуудаас статистик, тоон мэдээг авч, ярилцлагын удирдамжийн дагуу уулзалт, ганцаарчилсан ярилцлага хийж мэдээлэл цуглуулсан. Мөн олон улсын эрх зүйн болон үндэсний хууль тогтоомж, дүрэм журам, өмнө хийгдсэн судалгааны тайлангуудад дүн шинжилгээ хийсэн.

ХОЁР. ХЭРЭГЖИЛТИЙН ҮЕ ШАТ

Хэрэгжилтийн үе шатад үнэлгээний хүрээнд тусгагдсан бүлэг бүрийг тусгайлан судлах бөгөөд бүлэг тус бүр дээр үнэлгээ хийх зүйл, заалтыг тусгасан байна.

2.1 Олон улсын арбитрын тухай загвар хууль ба үндэсний хууль тогтоомж

Үнэлгээ хийхээр сонгосон заалт

№	Үнэлгээний шалгуур	Сонгосон зүйл заалт
1	Зорилгод хүрсэн түвшин	АтХ-ийн 1-р зүйлийн дагуу зорилтод хүрсэн эсэхийг АтХ-ийн бүх заалт дээр хийсэн ба Хавсралтын Хүснэгт 1-ээс харна уу.
2	Практикт нийцэж байгаа байдал	АтХ-ийн 13, 14, 15-р зүйл

Монгол Улсын Арбитрын тухай хуулийн 1-р зүйлд хуулийн зорилтыг тусгасан бөгөөд “Энэ хуулийн зорилт нь эрх зүйн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх ажиллагаатай холбоотой харилцааг олон улсын стандартад нийцүүлэн зохицуулахад оршино” хэмээн заажээ. Энэхүү хүрээнд, АтХ-ийг олон улсын стандартад нийцсэн эсэхийг НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын (ЮНСИТРАЛ) Загвар хуулийг зүйл, заалтуудтай нийцсэн эсэхэд үнэлгээ хийлээ. Ингэхдээ Загвар хуулийн зүйл, заалт болгоныг АтХ-д хэрхэн тусгагдсаныг Хавсралтад үнэлсэн ба ялгаатай зохицуулалтыг доорх хэсэгт тусгайлан орууллаа.

А. Арбитрын тухай хуулийн зорилт, зарчим, хэм хэмжээ нь ЮНСИТРАЛ-ын Загвар хууль, түүний нэмэлт өөрчлөлттэй нийцсэн байдал

НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын (ЮНСИТРАЛ) Загвар хуулийг олон улс орон, бизнесийн байгууллага, олон улсын арбитрын байгууллага, бүс нутгийн байгууллагын өргөн хүрээний хэлэлцүүлэг, зөвлөгөөнд үндэслэн боловсруулсан. Эдгээр хэлэлцүүлгийн үр дүнд гарсан загвар хуулийн төслийг ЮНСИТРАЛ 1985 онд тогтоолоор баталсан бөгөөд улсуудын олон улсын арилжааны арбитрын зохицуулалтыг ижилтгэх зорилготой олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арбитрын тухай баримт бичиг юм. Үүнээс хойш, 2021 оны байдлаар дэлхийн 110 орчим улс өөрсдийн дотоодын арбитрын тухай хуулийг түүнд нийцүүлэн баталсан нь олон улсын арилжааны арбитрын ижилтгэсэн зохицуулалтыг бий болгосон ач холбогдол бүхий баримт бичиг болохыг бататгаж байна. Иймд, загвар хуулийг баталсан улсын шүүхийн шийдвэр нь харьцангуй нэгдмэл олон улсын прецедентыг бий болгож эхлээд байна.

Монгол Улсын Арбитрын тухай хууль (Цаашид “АтХ” гэх) 9 бүлэг, 52 зүйлтэй. ЮНСИТРАЛ-ын Загвар хууль (Цаашид “Загвар хууль” гэх) 8 бүлэг, 36 зүйлтэй. Загвар хуулийн 1 дүгээр зүйлийн (5)-р хэсэг болон 2 А дугаар зүйл (1)-д зааснаас бусад бүх зохицуулалт АтХ-д шууд орчуулагдах байдлаар туссан байна. Загвар хуулийн 1 дүгээр зүйлийн (5):

“Энэ хууль нь тодорхой маргааныг арбитрын шүүхээр шийдвэрлүүлэхгүй, эсхүл зөвхөн өөр хуулийн зохицуулалтын дагуу арбитрын шүүхэд хандах тухай заасан тус улсын бусад хуулийн үйлчлэлд нөлөөлөхгүй”

Загвар хуулийн 2 А дугаар зүйл (1):

“Энэхүү хуулийг тайлбарлахдаа түүний олон улсын гарал үүсэл, түүний хэрэглээнд нэгдмэл байдал бий болгох, сайн санааны зарчмыг сахин биелүүлэхийг харгалзан үзнэ.”

Дээрхээс бусад зүйл заалтын дараалал, бүтэц тодорхой хэмжээгээр өөрчлөгдөн АтХ-д орсон байна. Үүний хүрээнд, дараах заалтуудыг жишээ болгон дурдлаа.

- Загвар хууль олон улсын арилжааны арбитраг хэрэглэгдэхээр боловсруулагдсан бол АтХ дотоодын болон олон улсын арбитрын ажиллагаанд аль алинд хамаарч байна. Үүнээс гадна, АтХ зөвхөн арилжааны маргаанд үйлчлэхээр хязгаарлагдахгүй бөгөөд дотоодын бусад тусгайлсан арбитраг (спортын, хөдөлмөрийн зэрэг) хэрэглэгдэхээр зохицуулагдсан байна. Иймд, Загвар хуульд зааснаас зарим зохицуулалтыг ялгамжтай байдлаар АтХ-д зохицуулсан байна. Тухайлбал, АтХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1: “Шүүхэд тусгайлан харьяалуулснаас бусад, арбитрын хэлэлцээрт тусгасан аливаа маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ” гэжээ.

Энэхүү заалт нь дан ганц арилжааны арбитраар хязгаарлагдаагүй тул арбитрайн хэлэлцээр бүхий бусад тусгай арбитраг хамаарах зохицуулалтыг ч оруулах нь зүйтэй юм. Тухайлбал, судалгааны ажлын гурав дугаар бүлэгт заасан тусгайлсан арбитрауд үүнд хамаарна. Тусгай арбитраудын үйл ажиллагааг тус хуулиар зохицуулахаа тэдгээрийн онцлогийг үндэслэж тусгаж болохоор байна

- Цаашлаад, АтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.2: *“Арбитрын бүрэлдэхүүн талуудын тохиролцсон эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхдээ уг тохиролцоонд тусгайлан заагаагүй бол түүнийг тухайн улсын материаллаг эрх зүйн хэм хэмжээ гэж ойлгож хэрэглэх бөгөөд үүнд иргэний эрх зүйн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх хэм хэмжээ хамаарахгүй.”*
- АтХ-ийн 15 дугаар зүйлийн 15.3: *“...хүсэлт гаргасан тал шийдвэрийг хүлээн авснаас хойш олон улсын арбитрайн ажиллагааны хувьд 30 хоногийн дотор, дотоодын арбитрайн ажиллагааны хувьд 14 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно...”*
- АтХ-д Арбитрч томилох, татгалзан гарах тухай загвар хуульд зааснаас нэмэлтээр зохицуулалт оруулсан. АтХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1:

“Талууд дараах шаардлагыг хангасан этгээдийг арбитрчаар томилж болно:

13.1.1.талуудын харилцан тохиролцож тогтоосон мэргэжил, ур чадварын тусгай шаардлагад нийцсэн;

13.1.2.хараат бус, бие даасан байх;

13.1.3.өөр ажил, албан тушаал хавсран эрхлэхийг хориглосон хуулийн шаардлагыг зөрчөөгүй байх.”

- АтХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.2-т арбитрчийг талуудын тохиролцсон мэргэжил, ур чадварын шаардлагад нийцээгүй, эсхүл арбитрчийн хараат бус, бие даасан байдалд эргэлзээ төрүүлэхүйц үндэслэл бүхий нөхцөл байдал байгаа үндэслэлээр татгалзахаас гадна “хуулиар тогтоосон шаардлагад нийцээгүй” бол татгалзах тухай нэмэлтээр зохицуулсан. Мөн АтХ-ийн 48 дугаар зүйлийн 48.1-д арбитрайн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэхэд 1958 оны Нью Йоркын конвенцод заасан журам үйлчилнэ гэж шууд заасан.
- Загвар хуульд зохицуулаагүй дараах асуудлыг АтХ-д нэмэлтээр хуульчилсан байна. Үүнд:
 - 7 дугаар зүйл. Арбитрын төрөл
 - 41 дүгээр зүйл. Арбитрын зардал,
 - 50 дугаар зүйл. Нууцлал,
 - 51 дүгээр зүйл. Дампуурал зэрэг багтана.
- ЮНСИТРАЛ-ын Загвар хуульд тусгагдсан **цахим процессын тухай**

Олон улсын жишиг хуулиудад арбитрайн цахим процессыг зохицуулах нь цөөнгүй байна. ЮНСИТРАЛ-ын Загвар хуулийн 2, 7, 9-р зүйлүүдэд тусгагдсан цахим харилцаа холбоо болон түүгээр дамжуулан талуудын хооронд маргаан шийдвэрлэх боломж, баримт бичиг, цахим нотлох баримт, арбитрайн шийдвэрийг цахимаар хүргүүлэх зэргийг Арбитрын тухай хуульд тусгаж өгсөн.

Харин арбитрайн процессыг цахимаар явуулах тухайд зохицуулалт ороогүй бөгөөд олон улсын жишгийг харахад хуулиар зохицуулагдах хэм хэмжээ нь цахим процессыг зөвшөөрөхөөр хязгаарлагдаж байна. Цаашлаад, арбитрайн байгууллагуудад арбитрайн цахим процессыг өөрсдийн дотоод журмаар зохицуулах боломжоор хангасан байна. Иймд, Арбитрын тухай хуульд арбитрайн цахим процессын хүчин төгөлдөр байдлыг тусгах шаардлагатай ба дотоодын арбитрайн байгууллагууд өөрсдийн журмаараа зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Дотоодын арбитрайн процессын журмуудад цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой дараах зохицуулалтыг тусгаж болохоор байна. Үүнд,

- Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх цахим ажиллагааг талууд сонгож болох эсэх,
- Цахим харилцаа холбоог ашиглан арбитрайн процессын явуулах тохиолдолд хувь хүний хувийн мэдээлэл, хэргийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан байх,
- Цахим ажиллагааны зохицуулалтад технологийн сонголтыг тодорхой заагаагүй ч онлайн арбитрайн ажиллагаанд ашигладаг технологийн найдвартай байдал, аюулгүй байдал, хүртээмжтэй холбоотой стандарт эсвэл хүлээлтийг агуулж болно.

Дүгнэвэл, Арбитрын тухай хуулийн дийлэнх заалт НҮБ-ын Загвар хуультай нийцэлтэй байгаа бөгөөд дотоодын эрх зүйн зохицуулалтын онцлогийг харгалзан арбитрын төрөл, зардал, нууцлал, дампуурал зэрэгтэй холбогдох заалтыг нэмэлтээр оруулсан байна. Гэвч зарим зохицуулалтыг илүү тодорхой болгох шаардлагатай байна. Үүнд:

- АтХ нь дотоодын болон олон улсын арбитрын маргаанд хэрэглэгдэхээр зохицуулагдсаныг харгалзан процессын ялгааг тодорхой болгох. Ингэхдээ, төрөлжсөн арбитрын маргаануудын зохицуулалтыг онцлогийг тусгах.
- АтХ-ийн 13.1.3-т заасан “өөр ажил, албан тушаал хавсран эрхлэхийг хориглосон хуулийн шаардлагыг зөрчөөгүй байх” шалгуурыг холбогдох хуулийн заалтуудаар дэлгэрүүлэх.
- АтХ-ийн 14.2-т заасан арбитрчийг татгалзан гаргах “хуулиар тогтоосон шаардлагад нийцээгүй” байх шаардлагыг холбогдох хуулийн заалтуудаар тодорхойлох.

Энэ нь АтХ-ийн 1-р зүйлд тусгагдсан “олон улсын стандартад нийцүүлэн зохицуулах” зорилтын хангаж байгаа бөгөөд энэ нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дагуу “зорилгод хүрсэн түвшин” шалгуурыг хангасан гэж үзэж байна.

Харин, “практикт нийцэж байгаа байдал” шалгуурыг бүрэн хангах хүрээнд дээр дурдсан тодруулыг холбогдох зүйл заалтуудад оруулах шаардлагатай бөгөөд судалгааны “Үнэлэх үе шат” хэсэгт зөвлөмжийг орууллаа.

В. ЮНСИТРАЛ-ын Загвар хууль дахь “notice” ба “claim” тухай ойлголт, ялгаа

Үнэлгээ хийхээр сонгосон заалт

№	Үнэлгээний шалгуур	Сонгосон зүйл заалт
1	Практикт нийцэж байгаа байдал	АтХ-ийн 4, 13, 15, 18, 21, 22, 23, 36, 46,47,49-р зүйл

ЮНСИТРАЛ-ын Загвар хуульд төсөөтэй болон ялгамжтай хэрэглэхдээ боломжтой “notice” буюу мэдэгдэл, “claim” буюу нэхэмжлэл гэсэн нэр томъёо ашиглагддаг бөгөөд тэдгээрийн заагийг тодорхойлох шаардлагатай. Энэ нь олон улсын арбитрын дүрмүүдэд “notice of claim” буюу нэхэмжлэл гаргасан тухай мэдэгдэл гэх ойлголт өргөн ашиглагддагтай мөн холбоотой.

Загвар хуулийн “notice” гэдэг нь АтХ-д “мэдэгдэл” гэсэн утгаар орсон бөгөөд арбитрын бүрэлдэхүүн талуудад мэдэгдэх, нэг тал нөгөө талдаа мэдэгдэх, талууд арбитрын бүрэлдэхүүнд мэдэгдэх утгатайгаар оржээ (*Хүснэгт 2-ыг харна уу*).

Хүснэгт 2. Notice буюу мэдэгдэл

ЮНСИТРАЛ Загвар хууль	Арбитрын тухай хууль
13 дугаар зүйл (3) after having received notice of the decision	15 дугаар зүйлийн 15.3 шийдвэрийг хүлээн авснаас хойш
16 дугаар зүйл (3) after having received notice of that ruling	18 дугаар зүйлийн 18.7 шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээн авснаас хойш
17 В дугаар зүйл (1) without notice to any other party	21 дүгээр зүйлийн 21.1 нэг тал нь бусад талдаа мэдэгдэхгүйгээр
17 С дугаар зүйл (1) the arbitral tribunal shall give notice to all parties...	22 дугаар зүйлийн 22.1 Арбитрын бүрэлдэхүүн ... мэдэгдлийг талуудад хүргүүлнэ.
17 С дугаар зүйл (4) after the party against whom the preliminary order is directed has been given notice and an opportunity to present its case.	22 дугаар зүйлийн 22.4 Урьдчилсан тогтоолыг холбогдох талд мэдэгдэж, тайлбар өгөх боломж олгосны дараа

17 D дугаар зүйл upon prior notice to the parties	23 дугаар зүйлийн 23.1 ...талуудад мэдэгдсэний үндсэн дээр
24 дүгээр зүйл (2) The parties shall be given sufficient advance notice of any hearing and of any meeting of the arbitral tribunal	36 дугаар зүйлийн 36.3 ... биечлэн оролцох хуралдаан, эсхүл арбитрын бүрэлдэхүүний уулзалтын талаархи мэдэгдлийг талуудад хангалттай хугацааны өмнө хүргүүлсэн байна.
33 дугаар зүйл (1) (a) a party, with notice to the other party, may request the arbitral tribunal to correct in the award any errors in computation, any clerical or typographical errors or any errors of similar nature;	46 дугаар зүйлийн 46.1 ...нэг тал нь нөгөө талдаа мэдэгдсэнээр арбитрын үндсэн шийдвэрийн үг үсэг, тооцоо, хэвлэлийн болон тэдгээртэй адилтгах бусад алдааг засуулах тухай арбитрын бүрэлдэхүүнд хүсэлт гаргаж болно.
33 дугаар зүйл (1) (b) a party, with notice to the other party, may request the arbitral tribunal to give an interpretation of a specific point or part of the award.	46 дугаар зүйлийн 46.2 ... нэг тал нь нөгөө талдаа мэдэгдсэнээр арбитрын үндсэн шийдвэрийн тодорхой хэсэг, зүйлийг тайлбарлуулах тухай хүсэлтийг талууд ... арбитрын бүрэлдэхүүнд гаргаж болно.
33 дугаар зүйл (3) a party, with notice to the other party, may request, within thirty days of <i>receipt of the award</i> , the arbitral tribunal to make an additional award...	46 дугаар зүйлийн 46.5 ... аль нэг тал нь нөгөө талдаа мэдэгдэж, ...нэмэлт шийдвэр гаргахыг үндсэн шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шаардаж болно.
34 дүгээр зүйл (2) (a) (ii) the party making the application was not given proper notice of the appointment of an arbitrator or of the arbitral proceedings or was otherwise unable to present his case; or	47 дугаар зүйлийн 47.2.1.б. өргөдөл гаргагч талд арбитрч томилох, арбитрын ажиллагааны тухай зохих ёсоор мэдэгдээгүйн улмаас арбитрын ажиллагаанд зохих ёсоор оролцох боломжгүй байсан;
36 дугаар зүйл (1) (a) (ii) the party against whom the award is invoked was not given proper notice of the appointment of an arbitrator or of the arbitral proceedings or was otherwise unable to present his case; or	49 дүгээр зүйлийн 49.1.1.б. арбитрын үндсэн шийдвэрээр үүрэг хүлээсэн талд арбитрч томилох, арбитрын ажиллагааны тухай зохих ёсоор мэдэгдээгүй, эсхүл арбитрын ажиллагаанд зохих ёсоор оролцож тайлбар өгөх боломжгүй байсан;

Харин загвар хуулийн 13 дугаар зүйл (3), 16 дугаар зүйл (3)-т заасан “notice” нь АтХ-ийн 15 дугаар зүйлийн 15.3, 18 дугаар зүйлийн 18.7-д “receipt” буюу “хүлээн авах” утгатайгаар орсон байна (*Хүснэгт 3-ыг харна уу*). Тодруулбал, Загвар хуульд “notice of the decision”, “notice of that ruling” гэж зохицуулагдсан байхад АтХ-д “шийдвэрийг хүлээн авснаас хойш” гэж хуульчилжээ. Энэ нь Загвар хуульд заасан “receipt” гэх хэллэгийн орчуулгатай ижил утгатай байна.

Хүснэгт 3. Receipt буюу хүлээн авах

ЮНСИТРАЛ Загвар хууль	Арбитрын тухай хууль
3 дугаар зүйлийн гарчиг <i>Receipt of written communications</i>	4 дүгээр зүйлийн гарчиг <i>Баримт бичгийг хүлээн авсанд тооцох</i>
11 дүгээр зүйл (3) (a) if a party fails to appoint the arbitrator within thirty days of receipt of a request to do so from the other party,	13 дугаар зүйлийн 13.4.1 Арбитрч томилох тухай хүсэлтийг нөгөө талаас хүлээн авсан тал тийнхүү хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор арбитрчаа томилоогүй,
33 дугаар зүйл (1) within thirty days of receipt of the award	46 дугаар зүйлийн 46.1 арбитрын үндсэн шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор

33 дугаар зүйл (1) (b) within thirty days of receipt of the request	46 дугаар зүйлийн 46.2 арбитрын үндсэн шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор
33 дугаар зүйл (3) within thirty days of receipt of the award	46 дугаар зүйлийн 46.5 үндсэн шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор

Загвар хуулийн “claim” гэдэг нь АтХ-д “нэхэмжлэл”, “нэхэмжлэлийн шаардлага” гэсэн утгаар орсон байна (*Хүснэгт 4-ийг харна уу*).

Хүснэгт 4. Claim буюу нэхэмжлэл, нэхэмжлэлийн шаардлага

ЮНСИТРАЛ Загвар хууль	Арбитрын тухай хууль
2 дугаар зүйл (f) claim	52 дугаар зүйлийн 52.2 нэхэмжлэл
7 дугаар зүйл (5) an arbitration agreement is in writing if it is contained in an exchange of statements of claim and defence	8 дугаар зүйлийн 8.8 Нэхэмжлэл болон хариу тайлбарт арбитрын хэлэлцээр байгаа талаар тусгаж,
8 дугаар зүйлийн гарчиг Arbitration agreement and substantive claim before court	10 дугаар зүйл Арбитрын хэлэлцээр ба шүүхэд нэхэмжлэл гаргах
17 А дугаар зүйл (1) (b) There is a reasonable possibility that the requesting party will succeed on the merits of the claim.	20 дугаар зүйлийн 20.1.2 маргааныг хүсэлт гаргагч талд ашигтайгаар шийдвэрлэх үндэслэлтэй магадлал байгаа;
23 дугаар зүйл (1) the claimant shall state the facts supporting his claim,	35 дугаар зүйлийн 35.1 нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болох үйл баримт, тайлбарыг...гаргаж өгөх үүрэгтэй.
23 дугаар зүйл (2) either party may amend or supplement his claim or defence	35 дугаар зүйлийн 35.3 талууд нэхэмжлэл, эсхүл тайлбараа өөрчлөх, нэмэлт оруулах эрхтэй.
25 дугаар зүйл (a) the claimant fails to communicate his statement of claim	37 дугаар зүйлийн 37.1 нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээ ... дэмжээгүй бол
32 дугаар зүйл (2) (a) the claimant withdraws his claim	45 дугаар зүйлийн 45.2.1 нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан
33 дугаар зүйл (3) an additional award as to claims	46 дугаар зүйлийн 46.5 нэхэмжлэлийн шаардлагын талаар нэмэлт шийдвэр
36 дугаар зүйл (2) on the application of the party claiming recognition or enforcement of the award	49 дүгээр зүйлийн 49.2 арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэх тухай өргөдөл хүлээн авсан

Дүгнэвэл, АтХ-ийн зохицуулалтад мэдэгдэл, нэхэмжлэл нь Загвар хуультай нийцэлтэй орсон байх бөгөөд дотоодын арбитрын байгууллагууд өөрсдийн дүрмээ боловсруулахдаа тус ойлголтуудын ялгааг анхаарах нь аливаа тодорхойгүй нөхцөл байдал үүсгэхээс сэргийлэх юм. Энэ нь “практикт нийцэж байгаа байдал” шалгуурыг хангаж байгааг илэрхийлж байна.

Г. ЮНСИТРАЛ загвар хуулийн арбитрын бүрэлдэхүүний эрх мэдэл, компетенц ба шүүхийн оролцоо

Үнэлгээ хийхээр сонгосон заалт

№	Үнэлгээний шалгуур	Сонгосон зүйл заалт
1	Практикт нийцэж байгаа байдал	АтХ-ийн 10, 11, 13, 15, 16, 18, 27, 29, 39, 47,48-р зүйл

Загвар хуулийн 5 дугаар зүйлд заасантай ижил хэллэгээр АтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Шүүх энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд арбитрын ажиллагаанд оролцож үл болно” гэж хуульчилсан. Арбитрын ажиллагаанд шүүх оролцож болох тухай тусгайлан заасан тохиолдлууд нь Загвар хууль болон АтХ-д ижил байна. Үүнд:

Хүснэгт 5. Арбитрын ажиллагаа дахь шүүхийн оролцоо

ЮНСИТРАЛ Загвар хууль	Арбитрын тухай хууль	Утга
11 дүгээр зүйл (3)	13.4 дүгээр зүйл	арбитрчийг томилох талаар тохиролцоонд хүрээгүй бол шүүх, эрх бүхий этгээд томилох
11 дүгээр зүйл (4)	13.5 дугаар зүйл	арбитрч томилох журам хэрэгжээгүй тохиолдолд хүсэлтээ шүүхэд гаргах
13 дугаар зүйл (3)	15.3 дугаар зүйл	арбитрч татгалзан гаргах хүсэлтийг хангаагүй тохиолдолд шүүхэд гомдол гаргах тухай
14 дүгээр зүйл	16 дугаар зүйл	арбитрчийн бүрэн эрхийг дуусгавар болгох талаар шүүх, эсхүл эрх бүхий этгээдэд хүсэлт гаргах
16 дугаар зүйл (3)	18.7 дугаар зүйл	арбитрын харьяаллын талаар гаргасан арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах
34 дүгээр (2)	47 дугаар зүйл	арбитрын үндсэн шийдвэрийн хүчингүй болгохоор хүсэлт гаргах
9 дүгээр зүйл	11.1 дүгээр зүйл	арбитраас гарах шийдвэрийн биелэлт баталгаажуулах арга хэмжээ авахуулахаар хүсэлт шүүхэд гаргах
27 дугаар зүйл	39.1 дүгээр зүйл	нотлох баримт бүрдүүлэхэд шүүх туслалцаа үзүүлэх
17 Н дугаар зүйл	27 дугаар зүйл	түр арга хэмжээг хүлээн зөвшөөрч гүйцэтгэх
17 J дугаар зүйл	29 дүгээр зүйл	шүүхээс түр арга хэмжээ авах
35 дугаар зүйл	48 дүгээр зүйл	үндсэн шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэх

Загвар хуульд заасан тохиолдлууд дээр нэмэлтээр АтХ-ийн 51 дүгээр зүйлд дампуурлын хэрэг үүсгэсэн шүүх дампуурлын ажиллагаатай холбоотой маргааныг арбитраг шилжүүлж болох тухай зохицуулалт орсон байна.

Загвар хуулийн 8 дугаар зүйлд арбитрын хэлэлцээртэй боловч шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болох нөхцөлүүдийг заажээ. Ийнхүү шүүхээс ажиллагааг дуусгавар болгохын тулд дараах урьдчилсан нөхцөлүүд хангагдсан байна. Үүнд:

- Арбитрын хэлэлцээртэй байх;
- Аль нэг тал тайлбар гаргахаас өмнө арбитрын журмаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан байх;
- Шүүх арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бус эсхүл биелүүлэх боломжгүй гэж үзээгүй байх.

Үүнтэй адилаар АтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1-д хуульчилжээ. Арбитрын тухай хуулийн 10.1-д “10.1.Арбитрын хэлэлцээртэй боловч шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд аль нэг тал тайлбар гаргахаасаа өмнө уг маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан бол шүүх аль нэг талын хүсэлтээр арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бус, эсхүл биелүүлэх боломжгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгоно” гэж заасан ба энэ нь **арбитрын харьяаллыг** тодорхойлоход ач холбогдолтой заалт юм.

Тус заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхэд, Загвар хуульд тусгасан зохицуулалттай нийцэж буй боловч хэргийн харьяаллыг тодорхой болгох үүднээс нарийвчлан томьёолох шаардлагатай. Тухайлбал, талуудын аль нэг нь тайлбар гаргаснаар арбитрын журмаар маргааныг шийдвэрлүүлэх хүсэлт хүлээж авахгүй мэт томьёолсон байгаа нь тодорхой бус байдал үүсгэх боломжтой. Мөн, талуудын хүсэл зоригийг илрэл, чөлөөт байдлын зарчим дээр үндэслэсэн арбитрын хэлэлцээрийн хүчин төгөлдөр эсэхийг заавал маргааны аль нэг тал хүсэлт гаргаснаар шийдвэрлэх нь зохимжгүй байж болох юм.

Загвар хуулийн 16 дугаар зүйлд арбитрын бүрэлдэхүүний маргаан харьяалан шийдвэрлэх эсэхээ өөрөө тогтоох эрхийн тухай болон арбитрын хэлэлцээр гэрээний бусад заалтаас тусдаа байх талаар заасан. Мөн арбитрын бүрэлдэхүүний маргаан шийдвэрлэх харьяаллын талаар гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл түүний талаарх мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд хандаж болох тухай заажээ. Энэ тухай мөн АтХ-ийн 18 дугаар зүйлээр зохицуулсан. Ийнхүү зохицуулахдаа талууд шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болохоор заасан байна.

Дүгнэлт

Ерөнхий байдлаар АтХ дахь арбитрын бүрэлдэхүүний эрх хэмжээ болон шүүхийн оролцоог зохицуулсан хэм хэмжээ нь олон улсын стандартад нийцэж байна. Гэхдээ, арбитрын маргааны харьяаллыг тодорхойлоход өндөр ач холбогдолтой 10-р зүйл, заалтын томьёоллыг тодорхой болгох шаардлагатай байна.

Арбитрын ажиллагаа дахь шүүхийн оролцооны үнэлгээг 2.4-р хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Д. ЮНСИТРАЛ Загвар хууль дахь “other authority” буюу “эрх бүхий этгээд”

Үнэлгээ хийхээр сонгосон заалт

№	Үнэлгээний шалгуур	Сонгосон зүйл заалт
1	Практикт нийцэж байгаа байдал	АтХ-ийн 6, 13, 16-р зүйл

Загвар хуулийн 11 (3), 11 (4), 11 (5), 13 (3) болон 14 (1) дүгээр зүйлд “other authority specified in article 6” гэж заасан. ЮНСИТРАЛ Нарийн бичгийн дарга нарын газрын тайлбар тэмдэглэлд үүнийг арбитрын байгууллага эсвэл Худалдаа аж үйлдвэрийг танхим зэрэг өөр эрх бүхий байгууллага гэж тодорхойлсон.

^[1] Харин АтХ-д үүнийг “эрх бүхий этгээд” гэж орчуулсан байна.

Загвар хуулийн 6 дугаар зүйлд “other authority” гэдгийг 6 дугаар зүйлд заасан чиг үүргийг гүйцэтгэх эрх хэмжээтэй бусад эрх бүхий этгээд гэж тодорхойлсон. Энэхүү эрх бүхий этгээд нь дараах чиг үүргийг гүйцэтгэхээр Загвар хуульд заажээ. Үүнд:

- **11 (3) дүгээр зүйл.** арбитрчийг томилох талаар талууд болон талуудаас томилогдсон арбитууд тохиролцоонд хүрээгүй бол аль нэг талын хүсэлтээр шүүх эсхүл эрх бүхий этгээд томилно.
- **11 (4) дүгээр зүйл.** Талуудын тохиролцсон арбитрч томилох журам хэрэгжээгүй тохиолдолд аль нэг тал шаардлагатай арга хэмжээ авахуулах хүсэлтийг шүүх эсхүл эрх бүхий этгээдэд гаргаж болно.
- **11 (5) дугаар зүйл.** Шүүх болон эрх бүхий этгээдийн гаргасан холбогдох шийдвэр эцсийн шийдвэр байна. Шүүх эсхүл эрх бүхий этгээд арбитрч томилохдоо арбитрын хэлэлцээрт заасан шаардлагыг харгалзах ба арбитрчийн хараат бус, бие даасан байх шаардлага хангасан этгээдийг томилно. Шүүх эсхүл эрх бүхий этгээд дангаар шийдвэрлэх эсхүл гурав дахь арбитрчийг томилохдоо талуудаас өөр иргэншилтэй арбитрчийг боломжтой бол томилно.
- **13 (3) дугаар зүйл.** Арбитрчийг татгалзан гаргах журмын дагуу гаргасан аль нэг талын хүсэлтийг хангаагүй тохиолдолд шүүх эсхүл эрх бүхий этгээдэд гомдол гаргах тухай заасан. Шүүх эсхүл эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэр эцсийн шийдвэр болно.
- **14 (1) дүгээр зүйл.** Арбитрч үүргээ гүйцэтгэж чадахгүй үндэслэл байгаа гэж үзвэл аль нэг

тал шүүх эсхүл эрх бүхий этгээдэд арбитрчийн бүрэн эрхийг дуусгавар болгох тухай хүсэлт гаргаж болно.

АтХ-д “эрх бүхий этгээд”-ийн тухай дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

- АтХ-ийн 13.4 дүгээр зүйл нь Загвар хуулийн 11 (3) дугаар зүйлтэй нэгэн адил арбитрчийг томилох талаар тохиролцоонд хүрээгүй бол шүүх, эрх бүхий этгээд томилох тухай заажээ. Гэвч “эрх бүхий этгээд”-ийн тодорхойлолтыг өгөөгүй бөгөөд энэ нь тодорхойгүй байдлыг үүсгэх, хуулийг өргөнөөр тайлбарлах зэрэг нөлөөтэй юм.
- Мөн АтХ-ийн 16.1-д арбитрч үүргээ гүйцэтгэж чадахгүй, эсхүл гүйцэтгэх боломжгүй болох тухай эргэлзээ төрүүлэхүйц үндэслэл байгаа бол арбитрчийн бүрэн эрх дуусгавар болгох талаар шүүх эсхүл эрх бүхий этгээдэд хүсэлт гаргаж болохоор заасан байна. Эдгээр нь Загвар хуульд заасантай ижил байна.

Харин

- АтХ-ийн 6 дугаар зүйлд зөвхөн шүүхийн оролцооны талаар зохицуулсан буюу эрх бүхий этгээд арбитрын ажиллагаанд оролцох тухай нийтлэг байдлаар хуульчлаагүй.
- АтХ-ийн 13.5 дугаар зүйлд талуудын тохирсон арбитрч томилох журам хэрэгжээгүй тохиолдолд талууд арбитрч томилуулах хүсэлтээ зөвхөн шүүхэд гаргах тухай заасан байна.
- АтХ-ийн 15.3-д зааснаар зөвхөн шүүхэд арбитрч татгалзан гаргах хүсэлтийг хангаагүй шийдвэрийн тухайд гомдол гаргаж болохоор байна.
- Мөн АтХ-ийн 13.7, 13.8 дугаар зүйлд заасан шийдвэр эцсийн байх зохицуулалт нь зөвхөн шүүхэд хамааралтай байдлаар хуульчлагджээ. Үүгээрээ Загвар хуульд зааснаас ялгаатай байна.

Е. Арбитрын харьяаллын тухай

Арбитрын тухай хуулийн 9.1-д заасны дагуу арбитрын харьяалал нь *“Шүүхэд тусгайлан харьяалуулснаас бусад, арбитрын хэлэлцээрт тусгасан аливаа маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ”* гэснийг ойлгохоор байна. Энэ нь талууд аливаа маргааныг өөрсдийн хүсэл сонирхол, тохиролцооны үндсэн дээр арбитраар шийдвэрлүүлэх боломжтойг тусгажээ. Мөн үүнд тавигдах хязгаарлалт нь шүүхийн харьяаллын маргаан байх юм.

Олон улсын жишигт арбитрын харьяаллыг тодорхойлохдоо дан ганц шүүхийн харьяаллаар хязгаарладаггүй бөгөөд тусгайлах “хувийн эрх зүйн харилцааны маргаан” хэмээн тодотгодог байна. Тухайлбал, дээрх зохицуулалтуудыг ОХУ-ын арбитрын кодекс, ХБНГУ-ын арбитрын тухай хууль болон Сингапур улсын арбитрын хуулиас харах боломжтой.

Ийнхүү хувийн эрх зүйн харилцаа хэмээн тодотгосноор спорт, хөдөлмөр зэрэг хосолсон эрх зүйн зохицуулалт байх боломжтой салбарын тусгайлсан арбитрауд захиргааны шинж чанартай маргаан шийдвэрлэхийг хязгаарлах боломжтой юм. Гэхдээ, онолын хувьд тусгайлсан арбитрауд олон улсын онцгой зохицуулалт бүхий харилцааны маргааныг шийдвэрлэдэг тул тусгайлсан хуультай байх шаардлагатай ба энэ нь спортын арбитрын үйл ажиллагаанд илүү хамаарна (2.3-р хэсгийг харна уу).

Арбитрын тухай хууль ба ИХШХШТХ

Арбитрын харьяаллын маргааныг үнэлэх хүрээнд Монгол Улсын ИХШХШТХ-ийг давхар авч үзэх нь зүйтэй. Энэ нь арбитрын харьяаллыг тодорхойлоход ач холбогдолтой юм.

Тухайлбал, ИХШХШТХ-ын 13-р зүйлийн 13.2-т *“Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан буюу зохигч хэлэлцэн тохиролцсон бол иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитр шийдвэрлэнэ”* гэжээ. Харин гагцхүү маргааныг эрх зүйн салбарыг тодорхой заагаагүй байгаа нь дээр үл ойлголцол үүсгэх боломжтой юм.

Ж. Үнэлгээг үндэслэн гаргасан дүгнэлт, зөвлөмж

1. Арбитрын тухай хууль нь олон улсын стандартад нийцсэн эсэх: Арбитрын тухай хуулийн дийлэнх заалт НҮБ-ын Загвар хуультай нийцэлтэй байгаа бөгөөд дотоодын эрх зүйн зохицуулалтын онцлогийг харгалзан арбитрын төрөл, зардал, нууцлал, дампуурал зэрэгтэй холбогдох заалтыг нэмэлтээр оруулсан байна. Гэвч зарим зохицуулалтыг илүү тодорхой болгох шаардлагатай байна. Үүнд:
2. Арбитрын тухай хууль нь дотоодын болон олон улсын арбитрын маргаанд хэрэглэгдэхээр

- зохицуулагдсаныг харгалзан процессын ялгааг тодорхой болгох. Ингэхдээ, төрөлжсөн арбитрын маргаануудын зохицуулалтыг онцлогийг тусгах.
3. Арбитрын тухай хуулийн 13.1.3-т заасан “*өөр ажил, албан тушаал хавсран эрхлэхийг хориглосон хуулийн шаардлагыг зөрчөөгүй байх*” шалгуурыг холбогдох хуулийн заалтуудаар дэлгэрүүлэх.
 4. Арбитрын тухай хуулийн 14.2-т заасан арбитрчийг татгалзан гаргах “*хуулиар тогтоосон шаардлагад нийцээгүй*” байх шаардлагыг холбогдох хуулийн заалтуудаар тодорхойлох.
 5. Энэ нь Арбитрын тухай хуулийн 1-р зүйлд тусгагдсан “олон улсын стандартад нийцүүлэн зохицуулах” зорилтын хангаж байна. Харин, “практикт нийцэж байгаа байдал” шалгуурыг бүрэн хангах хүрээнд дээр дурдсан тодруулыг оруулах шаардлагатай.
 6. Загвар хууль зөвхөн олон улсын арилжааны маргаанд үйлчлэх онцлогийг харгалзан, дотоодын болон олон улсын шинж бүхий иргэн, арилжааны маргааныг шийдвэрлэх арбитрын ажиллагааг зохицуулах зорилго бүхий АтХ болгон зохих өөрчлөлт болон нэмэлт оруулсан байна. Мөн АтХ-ийн зохицуулалт арилжааны маргаанаар хязгаарлагдаагүйг онцлон бусад тусгайлсан арбитраг хамаарах зохицуулалтыг тусгах нь зүйтэй юм.
 7. Эрх бүхий этгээдийн тухай зохицуулалт Загвар хуульд зааснаас явцуу хүрээнд буюу зарим тохиолдолд талууд эрх бүхий этгээдэд хандах боломжгүйгээр зөвхөн шүүхэд хандахаар Арбитрын тухай хуульд зохицуулсан байна. Энэ нь арбитрын бүрэлдэхүүний эрх мэдлийг хязгаарлах, цаашлаад арбитрын ажиллагаанд шүүхийн оролцоог нэмэгдүүлэх, улмаар ажиллагааны хугацаа, зардал зэргийг нэмэгдүүлэх сөрөг үр дагавартай тул олон улсын жишигт нийцүүлэх “эрх бүхий этгээд”-д хэн багтах, арбитрын бүрэлдэхүүн багтах бол тэдгээрийн эрх хэмжээ зэргийг хуульчлах нь зохимжтой юм.
 8. ЮНСИТРАЛ-ын Олон улсын арилжааны арбитрын тухай загвар хууль нь дотоодын төдийгүй олон улсын хэрэг маргаанд хэрэглэгдэхээр боловсруулагдсан. Иймд, АтХ-ийг дан ганц дотоодын маргаан гэлтгүй олон улсын маргаанд давхар хэрэглэгдэх байдлыг нь олон улсын стандартад нийцүүлэх нь зүйтэй юм. Ингэснээр, арбитрын ажиллагааны онцлог болох маргааныг шүүхийн журмаас илүү хурдан, хялбараар шийдвэрлэх; талуудын эрх тэгш, шударга, зөвшилцсон байдлыг хангах; болон эцсийн шийдвэрийн хэрэгжилтийг хялбаршуулах зэргийг хэрэгжүүлэх боломжтой юм.
 9. Арбитрын тухай хуульд арбитрын цахим процессын хүчин төгөлдөр байдлыг тусгах шаардлагатай ба дотоодын арбитрын байгууллагууд өөрсдийн журмаараа зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай.
 10. Арбитрын харьяаллын маргааныг тодорхойлохдоо дан шүүхийн харьяаллаар хязгаарлах бус зохицуулах харилцааны салбарыг “хувийн эрх зүй” хэмээн тодотгох нь захиргааны болон бусад маргааныг арбитраар шийдвэрлүүлэх тохиолдлыг хязгаарлах юм.
 11. АтХ-д арбитрын ажиллагааны журмыг “дүрэм” хэмээн нэрлэсэн байгаа нь үл ойлголцол үүсгэх боломжтой бөгөөд олон улсын практикт нийцүүлэн “арбитрын ажиллагааны журам” гэвэл зохимжтой.

2.2 Арбитрын тухай хуулийн зохион байгуулалтын хэрэгжилт, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж буй арбитрын байгууллагууд

Арбитрын тухай хуулийн 7-р зүйлд зааснаар арбитрын үйл ажиллагааг байнгын болон байнгын бус арбитраг хэрэгжүүлж болно. Тус заалтыг үндэслэн энэ хэсэгт АтХ-д заасан арбитрын төрлийг авч үзнэ.

Үнэлгээ хийхээр сонгосон заалт

№	Үнэлгээний шалгуур	Сонгосон зүйл заалт
1	Практикт нийцэж байгаа байдал	АтХ-ийн 7-р зүйл 7.1. Арбитр нь байнгын, эсхүл түр байж болно. 7.2. Байнгын арбитр нь арбитрын ажиллагааны дүрэмтэй байна. Байнгын арбитр нь энэ хуулийн 13.4, 16.1-д заасан хүсэлтийг эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэхээр дүрэмдээ зааж болно. 7.3. Монгол Улсад байнгын арбитрыг худалдаа, аж үйлдвэрийн танхим, худалдаа үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн зэрэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд байгуулж болно. 7.4. Энэ хуулийн 7.3-т заасан байнгын арбитр нь арбитрын ажиллагааг явуулах байр, хүний нөөцтэй байна. 7.5. Түр арбитрыг талуудын харилцан тохиролцсон журмын дагуу байгуулна.

А. Байнгын болон байнгын бус (ad hoc) арбитраын зохицуулалтын онцлог

Олон улсын арбитр байнгын болон байнгын бус гэсэн хоёр төрөлтэй. Эдгээр нь онолын болон практикийн хувьд ялгаатай юм. Байнгын арбитр мэргэшсэн байгууллагын тогтсон дүрмийн дагуу явагддаг. Тухайн байгууллагаас арбитраын ажиллагаа явуулахад талууд захиргааны туслалцаа, дэмжлэг авдаг. Талууд арбитрачийг сонгох тохиролцоонд хүрч чадаагүй бол тус байгууллага арбитрач томилох үүргийг гүйцэтгэдэг. Харин байнгын бус арбитраын ажиллагаа нь томилох эрх бүхий этгээдийн оролцоо болон тогтсон дүрэмгүйгээр явагддаг. Иймд байнгын бус арбитр нь зөвхөн талуудын хэлэлцээр болон зохих улсын арбитраын хууль тогтоомжийн дагуу явагддаг.

Байнгын арбитр

Байнгын арбитр гэдэг нь арбитраын ажиллагааг мэргэшсэн арбитраын байгууллага удирдан явуулах, хяналт тавих үйл явц бөгөөд тогтсон тодорхой дүрэм, төлбөрийн хуваарь дээр үндэслэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа юм. Талуудын маргааныг арбитраын байгууллага шууд шийдвэрлэдэггүй. Маргаан шийдвэрлэх нь талуудаас сонгогдсон эсвэл байгууллагаас томилогдсон арбитрачийн үүрэг юм. Арбитраын байгууллага нь талууд болон арбитрачийн хооронд гүүр болж, төвийг сахисан, нэгдмэл, үр ашигтай байдлыг хадгалахад тусалдаг.

Дэлхий дахинд арбитраын хэрэглээ нэмэгдэхийн хэрээр олон улсын болон дотоодын арилжааны маргааныг хянан шийдвэрлэх олон байгууллага бий болсон. Байгууллага бүр ялгаатай орон тоотой ба шийдвэр гаргах байгууллагатай байдаг. Байгууллага бүр өөрийн гэсэн онцлогтой бөгөөд талууд тодорхой нэг байгууллагыг сонгохоос өмнө захиргааны дэмжлэгийн түвшнийг судлахаас гадна холбогдох дүрэм, төлбөрийн бүтцийг харгалзан үздэг. Хамгийн алдартай олон улсын арбитраын байгууллагууд бол Олон улсын худалдааны танхим (ICC), Сингапурын олон улсын арбитраын төв (SIAC), Америкийн арбитраын холбоо (AAA) болон түүний маргаан шийдвэрлэх олон улсын төв (ICDR), Лондоны олон улсын арбитраын шүүх (LCIA), Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төв (ICSID) болон Байнгын арбитраын шүүх (PCA) юм.

Эдгээр болон бусад арбитраын байгууллагууд нь тус байгууллагын дүрмийн дагуу арбитраын ажиллагаа явуулахаар талууд тохиролцсон тохиолдолд дагаж мөрдөх багц дүрмийг нийтэлсэн бөгөөд талууд ихэвчлэн арбитраын хэлэлцээртээ тус дүрмийг тусгадаг. Эдгээр дүрмүүд нь арбитраын ажиллагааны үндсэн журмыг тогтоож, арбитраын байгууллагад тодорхой маргаанд арбитрачийг сонгоход дэмжлэг үзүүлэх, арбитрачид тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, шүүх хуралдаан явагдах газрыг бэлтгэх, арбитрачид төлөх төлбөрийг тогтоох, зарим тохиолдолд арбитрачийн шийдвэрийг хянан үзэх, шийдвэр бодит байдалд хэрэгжих боломжгүй байх эрсдэлийг бууруулах зэрэг эрхийг олгодог.

Олон байгууллага арилжааны гэрээнд тусгаж болох арбитраын заалтыг санал болгодог. Талууд арбитраын байгууллагыг сонгосны дараа тухайн байгууллагаас санал болгож буй заалтыг гэрээндээ тусгадаг. Ийнхүү маргаан үүсэхээс өмнө гэрээндээ заах нь асуудлыг шийдвэрлэх хамгийн үр дүнтэй арга юм. Нэгэнт маргаан үүссэний дараа ийм механизмын талаар тохиролцоход хүндрэлтэй байх боломжтой.

Арбитраын байгууллагаас санал болгож буй арбитрачид нь ихэвчлэн дэлхийн янз бүрийн бүс нутгийн мэргэжилтнүүдээс бүрдэх бөгөөд олон янзын мэргэжилтэн байдаг. Энэ нь талуудад маргааныг хурдан бөгөөд үр дүнтэй шийдвэрлэхэд шаардлагатай ур чадвар, туршлага, мэргэшил бүхий арбитрачийг сонгох боломжийг олгодог. Гэвч энэ байгууллага зөвхөн арбитрачийг томилдог гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Тодруулбал, талууд арбитрачийг сонгох бөгөөд тухайн арбитраын байгууллага тус арбитрачийг шаардлагатай ур чадвар, мэргэшилгүй, шударга бусаар ажиллахгүй гэж үзвэл томилохоос татгалзах эрхтэй байдаг.

Байнгын арбитраын давуу тал

- ◆ **Урьдчилан тогтоосон журам:** Байнгын арбитраын үйл ажиллагаа мэргэжлийн арбитраын байгууллагын журмын дагуу явагддаг. Ихэнх тохиолдолд эдгээр дүрэм нь нэлээд боловсронгуй байдаг. Байгууллагын дүрэм нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхнээс нь дуустал цогцоор нь зохицуулахад зориулагдсан байдаг тул үүсэж болох гэнэтийн нөхцөл байдалд бэлэн байдаг.
- ◆ **Тогтсон бичлэг бүхий арбитраын заалт:** Талууд арбитраын байгууллагыг сонгосны дараа тухайн байгууллагаас санал болгож буй бэлэн арбитраын заалтыг гэрээндээ тусгаснаар цаг хугацаа хэмнэхээс гадна маргаан бүхий хоёрдмол утга бүхий заалт гэрээндээ тусгахаас сэргийлдэг. Арбитраын заалтын бас нэг давуу тал нь тухайн байгууллага арбитраын ажиллагааны туршлагад үндэслэн тогтмол шинэчлэн найруулж, арбитраын практикт гарсан сүүлийн үеийн дэвшлийг харгалзан боловсруулсан байдаг явдал юм.

- ♦ **Захиргааны туслалцаа:** Арбитрын байгууллагын өөр нэг давуу тал нь талууд болон арбитрч байгууллагын дүрмийн дагуу арбитрыг удирдах, хяналт тавих үүрэгтэй байгууллагын ажилтнуудаас тусламж, зөвлөгөө авах боломжтой байдаг. Тиймээс шүүхийн оролцоогүйгээр арбитрын ажиллагаанд гарсан эргэлзээг арилгах боломжтой.
- ♦ **Мэргэшсэн арбитрч нарын жагсаалт ба арбитрчийг томилох:** Арбитрын байгууллагын ажиллагаанд арбитрчийг талууд тухайн байгууллагын арбитрч нарын зөвлөлөөс сонгодог. Энэ нь маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай туршлага, мэдлэгтэй арбитрчийг сонгох боломжийг олгож, улмаар маргааныг хурдан бөгөөд үр дүнтэй шийдвэрлэхэд хувь нэмэр оруулдаг.
- ♦ **Арбитрын шийдвэрт хяналт тавих:** Арбитрын нэг давуу тал нь давж заалдах боломжгүй эцсийн бөгөөд заавал биелүүлэх шийдвэрийг гаргадаг явдал юм. Гэвч арбитрын шүүхээс гаргасан алдааг дараагийн шатанд засаж залруулахгүй байх эрсдэлтэй. Энэхүү эрсдэлийг тэнцвэржүүлэхийн тулд зарим байгууллагын дүрэмд эцсийн шийдвэр гаргахаас өмнө шийдвэрийн төслийг арбитрын байгууллага нягтлан шалгахгаар заасан байдаг. Жишээ нь, Олон улсын худалдааны танхимын олон улсын арбитрын шүүхийн дүрмийн дагуу арбитрч нь арбитрын шийдвэрт гарын үсэг зурахаас өмнө арбитрын байгууллагын зөвшөөрлийг авах ёстой байна. Түүнчлэн байгууллага нь тодорхой шалтгааны улмаас арбитрчийг солих эрхтэй.

Байнгын арбитрын сул тал

Байнгын арбитрын сул талд уян хатан бус байдал, шүүхийн захиргааны үйл ажиллагаа, сааталтай холбоотой зардал зэрэг орно:

- Их хэмжээний маргаан бүхий тохиолдолд үйлчилгээ, ашиглалтын захиргааны хураамж өндөр байж болно.
- Байгууллагын хүнд суртал нь нэмэлт зардал, саатал үүсгэж болзошгүй.
- Талууд процедурын шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай нь арбитрын шүүх хуралдааныг шаардлагагүй хойшлоход хүргэх боломжтой.

Байнгын бус буюу түр арбитр

Түр арбитр гэдэг нь талууд болон арбитрчид нь талуудын өмнө тохиролцсон журмын дагуу, талууд ийнхүү тохиролцоонд хүрээгүй тохиолдолд арбитрын шүүхээс арбитрын ажиллагаа эхэлсний дараа урьдчилсан хуралдаанаас тогтоосон журмын дагуу явуулах арбитрын ажиллагаа юм. Иймд түр арбитр гэдэгт аль нэг арбитрын байгууллагад хандахгүйгээр талууд өөрсдөө тохиролцож, зохион байгуулсан арбитрыг ойлгоно. Түр арбитрт арбитрын ажиллагааг аль нэг байгууллага удирддаггүй тул арбитрчийн тоо, тэднийг томилох арга, арбитрын ажиллагаа явуулах журам гэх мэт арбитрын бүх асуудлыг талууд тодорхойлох шаардлагатай байдаг. Түр арбитрын үндсэн шинж чанарууд нь:

- Бие даасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тул уян хатан байх;
- Арбитрчийг талууд сонгох (хэдийгээр тохиролцоонд хүрч чадахгүй бол томилох эрх бүхий байгууллагад шилжүүлж болно);
- Шийдвэрийг арбитрын байгууллага хянан хэлэлцэхгүй.

Талууд арбитрт хамтран ажиллах сэтгэлээр хандсан тохиолдолд арбитрын ажиллагаа нь арбитрын байгууллагын хянан шийдвэрлэх ажиллагаанаас илүү уян хатан, хямд, хурдан байх боломжтой. Захиргааны хураамж байхгүй нь түр арбитрыг сонгоход ихээхэн нөлөөлдөг. Гэвч түр арбитрын үйл ажиллагааг байнгын арбитрын оролцооноос бүрэн тусгаарлагдсан гэж үзэж болохгүй. Ихэнхдээ мэргэшсэн ба шударга арбитрчийг сонгоход талууд тохиролцоонд хүрч чаддаггүйгээс түр арбитрын ажиллагаанд саад учирдаг. Энэ тохиолдолд талууд харилцан тохиролцож арбитрын байгууллагыг арбитрч томилох эрх бүхий этгээдээр тогтоож болно.

Тусгайлан боловсруулсан дүрэм, албан ёсны удирдлага, хяналт шаардлагагүй, түр арбитрын ажиллагаа явуулах хүсэлтэй талуудад боломжтой сонголтууд нь:

- арбитрчийг сонгох заалтыг өөрчлөх, арбитрыг тухайн байгууллага удирдан явуулах тухай заалтыг хасах гэх мэтээр арбитрын байгууллагын тогтсон дүрмийг өөрчлөх;
- АНУ-ын Холбооны Арбитрын тухай хууль эсвэл 1996 оны Английн Арбитрын тухай хууль зэрэг дотоодын хуулиар тогтоосон журмыг хэрэглэх;
- UNCITRAL Арбитрын дүрэм эсвэл CPR дүрэм (Мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх олон улсын тогтоол) зэрэг дотоодын болон олон улсын маргаанд ашиглаж болох арбитрын ажиллагаанд тусгайлан боловсруулсан дүрэм ашиглах;
- өөр гэрээнд заасан түр арбитрын ажиллагаа явуулах дүрмийг хуулбарлан ашиглах гэх мэт.

Байнгын бус арбитрын давуу тал

Түр арбитрын үндсэн давуу тал нь уян хатан байдал бөгөөд энэ нь талуудад маргаан шийдвэрлэх процедурын талаар шийдвэр гаргах боломжийг олгодог. Талууд хоорондоо байгуулсан гэрээндээ түр арбитрын тухай заалт оруулахыг хүсэж байгаа эсвэл маргаан үүссэний дараа арбитрын нөхцөлийг тохиролцохыг хүссэн тохиолдолд талууд өөрсдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн иж бүрэн дүрмийн талаар хэлэлцээ хийх боломжтой. Энэ нь арбитрын дүрмийг тодорхойлоход талуудын илүү их хүчин чармайлт, хамтын ажиллагаа, туршлага шаарддаг. Түүнчлэн, маргаан гарсны дараа талууд санал нийлэхгүй байх хандлагатай байдаг бөгөөд шаардлагатай хамтын ажиллагаа байхгүй байх нь талуудын маргааныг түр арбитраар шийдвэрлүүлэх үйл ажиллагаанд саад учруулж болзошгүй юм.

Хэрэв талууд арбитрын ажиллагааг тодорхой дүрмийн дагуу явуулах ёстой гэж тохиролцсон бол энэхүү нөхцөл байдлаас зайлсхийх боломжтой. Үүний үр дүнд талууд арбитрын нарийн дүрмийг тодорхойлоход цаг хугацаа шаардсан үйл явцад оролцдоггүй тул хэлэлцүүлэг, өмгөөллийн үйлчилгээний төлбөрийг хэмнэх, арбитрын ажиллагааг эрт эхлүүлэхэд тусалдаг. Түр арбитрын ажиллагаанд тохиромжтой олон төрлийн дүрмүүд байдаг бөгөөд эдгээрээс UNCITRAL-ийн дүрэм нь хамгийн тохиромжтой гэж үздэг.

Түр арбитр нь арбитрын байгууллагаас бага зардалтай байдаг. Талууд зөвхөн арбитрч, өмгөөлөгч, төлөөлөгчийн хөлс, арбитрыг явуулахад гарсан зардал, тухайлбал арбитрчийн зардал, арбитрын хурал явагдах газрын төлбөр зэргийг төлдөг. Талууд арбитрын байгууллагад төлбөр төлөх шаардлагагүй.

Түүнчлэн арбитрын байгууллагаас тогтоосон арбитрын төлбөрийг талууд төлөхөөс ялгаатай нь түр арбитрын ажиллагаанд талууд арбитрч нартай шууд хэлэлцээ хийж, хураамжийн асуудлыг шийддэг. Энэ нь талуудад төлбөрийг бууруулах талаар хэлэлцээр хийх боломжийг олгодог. Хэдийгээр түр арбитр нь илүү уян хатан боловч дараах тохиолдолд л зардал багатай байна гэж үздэг:

- талуудын хооронд шаардлагатай хамтын ажиллагаа байгаа;
- талууд арбитрын ажиллагааг ойлгодог;
- арбитрыг туршлагатай арбитрауд явуулах.

Байнгын бус арбитрын сул тал

Талууд хоорондоо байгуулсан гэрээндээ түр арбитрын тухай заалт оруулахыг хүсэж байгаа эсвэл маргаан үүссэний дараа арбитрын нөхцөлийг тохиролцохыг хүссэн тохиолдолд талууд өөрсдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн иж бүрэн дүрмийн талаар хэлэлцээ хийх боломжтой. Гэвч энэ арга нь ихээхэн цаг хугацаа, анхаарал, зардал шаарддаг тул тохиролцсон нөхцөлүүд нь бүх боломжит нөхцөл байдлыг шийдвэрлэх баталгаагүй юм. Түүнчлэн, аливаа маргаан гарахаас өмнө талууд арбитрын нөхцөлөө тохиролцоогүй бол маргаан үүссэний дараа тэд бүрэн хамтран ажиллах боломжгүй байдаг.

Түр арбитрын хувьд арбитрчийг томилох нь талуудын арбитрчид итгэх итгэл, итгэлцэл дээр суурилдаг бөгөөд заавал тэдний мэргэшил, туршлага дээр үндэслэдэггүй. Иймд чадваргүй арбитрч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг жигд явуулахгүй байх ба энэ нь маргааныг шийдвэрлэх явцыг удаашруулж, зардал нэмэгдэхэд хүргэж болзошгүй юм. Түр арбитрын ажиллагаанд талууд арбитрыг урагшлуулахын тулд шүүхэд хандахаас өөр аргагүй болж, улмаар түр арбитрын зардлын давуу тал шүүхийн зардлаар үгүйсгэгдэх эрсдэлтэй.

Дүгнэлт, зөвлөмж

Олон улсын арилжааны болон бусад арбитрын төрлийг байнгын болон байнгын бус хэмээн ангилах нь стандарт зохицуулалт бөгөөд өөрсдийн гэсэн онцлогтой байна. Харин Монгол Улсын дотоодын зохицуулалтад байнгын арбитрыг тодорхой зохицуулсан боловч байнгын бус арбитрын төдийлөн онцлон зохицуулж чадаагүй байна. Үүний улмаас, маргааны талууд байнгын бус арбитраар маргаан шийдвэрлүүлэх нь бага байх боломжтой. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын хувьд, АтХ-ийн 7-р зүйлд тусгагдсан арбитрын төрлүүдийн нэг болох байнгын бус арбитрын ойлголт, зохицуулалтын онцлог зэрэг нь хангалтгүй байгаа бөгөөд үүний улмаас практикт хэрэгжих боломж нь хязгаарлагдмал байх юм. Иймд, Арбитрын тухай хуульд байнгын бус арбитраар маргаан шийдвэрлүүлэхэд анхаарах зохицуулалтуудыг тусгаж өгөх нь зүйтэй юм. Үүнд тухайлбал, гэрээний чөлөөт байдлын зарчмыг үндэслэн үүсгэн байгуулагдах түр арбитрын процессын журмын хуульд нийцсэн байдал, мэргэшсэн арбитрчийн тодорхойлолт болон шийдвэр биелэлтийг хангах зохицуулалтууд багтах боломжтой.

2.3 Байнгын арбитрын үйл ажиллагаа, зохицуулалт, практик

Үнэлгээ хийхээр сонгосон заалт

№	Үнэлгээний шалгуур	Сонгосон зүйл заалт
1	Зорилгод хүрсэн түвшин	АтХ-ийн 3 дугаар зүйл.Арбитрын ажиллагаа 3.1.Арбитрын ажиллагаа гэдэгт байнгын, эсхүл түр арбитраас явуулж байгаа арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагааг ойлгоно. АтХ-ийн 7 дугаар зүйл.Арбитрын төрөл 7.1.Арбитр нь байнгын, эсхүл түр байж болно. 7.2.Байнгын арбитр нь арбитрын ажиллагааны дүрэмтэй байна. Байнгын арбитр нь энэ хуулийн 13.4, 16.1-д заасан хүсэлтийг эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэхээр дүрэмдээ зааж болно. 7.3.Монгол Улсад байнгын арбитрыг худалдаа, аж үйлдвэрийн танхим, худалдаа үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн зэрэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд байгуулж болно. 7.4.Энэ хуулийн 7.3-т заасан байнгын арбитр нь арбитрын ажиллагааг явуулах байр, хүний нөөцтэй байна. 7.5.Түр арбитрыг талуудын харилцан тохиролцсон журмын дагуу байгуулна.
2	Практикт нийцэж байгаа байдал	Монгол улсад байнгын үйл ажиллагаа явуулж буй арбитрын байгууллагууд 1.МХАҮТ-ын дэргэдэх олон улсын арбитр 2. УБ хотын танхимын дэргэдэх Үндэсний ба Олон улсын арилжааны арбитр 3. Барилгын арбитр 4. Спортын арбитр 5. Хөдөлмөрийн арбитр

АтХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг болон 7 дугаар зүйлд заасны дагуу арбитрын үйл ажиллагааг байнгын болон байнгын бус арбитр хэрэгжүүлж болно. Энэхүү судалгааны тайлангийн өмнөх 3.2 дугаар бүлэгт бичсэнээр Монгол Улсад байнгын үйл ажиллагаа явуулж буй хэд хэдэн арбитр байгаа бол байнгын бус арбитраар хэргээ хянан шийдвэрлүүлсэн талаар мэдээлэл бүртгэгдээгүй ба энэ талаар шүүхээр арбитрын үйл ажиллагаанд оролцсон талаар энэхүү судалгааны ажлын хүрээнд тодорхойлоход хүндрэлтэй байсан.

Монгол Улсад арбитрын үйл ажиллагааг хэрэгжүүлж буй хэд хэдэн арбитр байгуулагдан ажиллаж байна. Эдгээр арбитр нь Арбитрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт зааснаар дүрмээ баталж мөн хэрэг хянан шийдвэрлэх журмаа ч баталсан байдаг. Монгол Улс дахь арбитрын байгууллагууд нь олон улсын ба дотоодын маргаан хянан шийдвэрлэдэг онцлогтой бөгөөд олон улсын маргаан шийдвэрлэдэг арбитууд (Тухайлбал, МХАҮТ-ын дэргэдэх арбитр олон улсын маргаан шийдвэрлэдэг. Жишээ нь Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн 1.1 дэх заалт).

Олон улсын арбитрын үйл ажиллагаа явуулж буй арбитрын байгууллагууд үйл ажиллагаагаа олон улсын стандартад нийцүүлэх зорилго тавьж дүрэм журмаа үүнд нийцүүлэхийг чухалчилсан байв. Монголын Олон улсын ба Үндэсний арбитрын Дүрмийн 1.3.1-т арбитрын ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх талаар заасан байна.

Дэлхийн олон орны олон улсын арбитрын үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд мөн олон улсын стандартад арбитрын ажиллагааг нийцүүлэхийг эрмэлзэж, дүрэм журмаа зохих ёсоор боловсруулсан байдаг. Жишээ нь арилжааны маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотойгоор Олон улсын худалдааны

арбитр (International Commercial Arbitration), Лондонгийн арбитр (London arbitration center), Америкийн арбитрын холбооны маргаан (American Arbitration Association dispute settlement center) шийдвэрлэх олон улсын төв, Сингапурын Арбитрын (Singapore International Arbitration) журам, Хонгконгийн арбитр (Hong Kong Arbitration) өөрсдийн журмаа гаргасан байдаг.

Байнгын олон улсын арбитрауд хэрэг хянан шийдвэрлэх дүрэм журмаа НҮБ-ын Олон улсын худалдааны эрх комиссын боловсруулсан ЮНСИТРАЛ-ын загвар журмыг жишиг болгон боловсруулсан байдаг.

Энэхүү загвар журмыг анх 1976 онд батлаад, 2010 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. ЮНСИТРАЛ-ын Загвар журам нь олон улсын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нийтлэг стандартын дагуу нэг мөр хэрэгжүүлэх, талуудад хянан шийдвэрлэх ажиллагааг урьдчилж таамаглах боломжтой, процессыг нийтээр тогтсон журмын дагуу хэрэгжүүлэхэд нь тустай гэж үздэг.

Арбитраар маргаан шийдвэрлүүлэхээр харилцан тохиролцсон талууд аль нэг байнгын үйл ажиллагаатай арилжааны арбитрын журмыг хэрэглэх нь нийтлэг юм. Цөөн хэдэн тохиолдолд талууд байнгын бус арбитрын байгууллагыг сонгоогүй ч байнгын арбитрын дүрэм эсхүл олон улсын загвар журмыг хэрэглэх нь нийтлэг байдаг.

Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам нь зохистой байх нь тухайн арбитрын үйл ажиллагааг үр дүнтэй, олон улсын стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх, шийдвэрийг нь биелүүлэх боломжтой болгодог. Арбитрын журам нь ялгаатай, талуудад ойлгомжгүй, эрхийг нь хязгаарласан байх нь тухайн арбитрад хандах тоо, итгэл итгэлийг бууруулах хандлагатай. Ийм ч учраас байнгын арбитрын байгууллагууд хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой олон улсын жишигт, ЮНСИТРАЛ-ын загвар журамд нийцсэн журам боловсруулах нь нийтлэг юм.

1923 онд Парис хотноо байгуулагдсан Олон улсын худалдааны арбитр (ICC) арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хэд хэдэн журам, тухайлбал, эвлэрүүлэн зуучлах, шинжээч томилох, арбитрын бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэх, урьдчилсан ажиллагааны журмыг тус тус баталж, журмаа үе үе шинэчилж ирсэн юм. Энэхүү арбитр нь хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой журмаа ЮНСИТРАЛ-ын загвар журамд нийцүүлсэн бөгөөд дунджаар жилд 1000 хэрэг шийддэг бөгөөд 60 гаруй улсад үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн юм. Сүүлийн 30 жилд мөн Сингапурын арбитр, Хонг Конгийн арбитр, Лондонгийн олон улсын арбитр хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа, түргэн шуурхай байдлаараа мөн олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, нэр хүндтэй болсон. Бусад орнууд ч мөн олон улсын арбитрыг байгуулсан бөгөөд ихэнх арбитрауд хэрэг хянан шийдвэрлэх журмаа олон улсын стандартад нийцүүлэхийг эрмэлзэх болсон. Мөн түүнчлэн хөдөлмөрийн, спортын, оюуны өмчийн, барилгын, даатгалын, далайн арбитрауд мөн байгуулагдах болсон. Эдгээр арбитрын байгууллагуудын амжилт нь дүрэм журам нь олон улсын жишиг, ЮНСИТРАЛ-ын загвар журамтай нийцсэн байдалтай холбоотой ч гэж судлаачид үздэг.

Монгол Улсад байнгын арбитрын үйл ажиллагааны хамгийн их урт түүхтэй нь Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын олон улсын арбитр юм. Олон улсын арбитр нь хэрэг хянан шийдвэрлэх дүрэм, арбитрагийн ёс зүйн дүрэм, Түр арбитрад дэмжлэг үзүүлэх тухай дүрэм, Арбитрын зардлын талаар журмыг тус тус баталсан байдаг.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд төрөлжсөн арбитрын байгууллагууд мөн байгуулагдах хандлага нэмэгдэж байна. Жишээ нь Барилгын арбитр, Монголын Олон улсын ба үндэсний спортын арбитр, хөдөлмөрийн арбитр байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж эхэлж байна. Улаанбаатар хотын худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэд мөн Үндэсний ба олон улсын арилжааны арбитр байгуулагдаж үйл ажиллагаа нь идэвхтэй хэрэгжиж байна.

Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон улсын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм нь бусад арбитрын байгууллагуудад жишээ болж мөн хэрэглэгдэж байгаа ч тохиолдол байна. Иймд уг арбитрын үүрэг оролцоо чухал бөгөөд дүрэм журам нь боловсонгүй байх нь Монгол улсад арбитрын үйл ажиллагааг үр дүнтэй, хуулийн дагуу хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд өндөр ач холбогдолтой. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журамд арбитрын ажиллагааг эхлүүлэх, нэхэмжлэл гаргах, тайлбар гаргах, арбитрад томилох, татгалзах, арбитрын хуралдааны газар, хэрэг хянан шийдвэрлэх арга хэмжээ, арбитрын ажиллагаа, түр арга хэмжээ, шийдвэр, зардал, хураамжийг нь зааж өгсөн байх жишээтэй.

А. Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх олон улсын арбитрын дүрэм, журам

Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Олон улсын арбитр (Цаашид Танхимын олон улсын арбитр) нь үйл ажиллагаагаа Арбитрын тухай хууль, Арбитрын дүрэм болон Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм болон бусад холбогдох журмын дагуу хэрэгжүүлдэг. Тус арбитрын шийдвэрлэсэн хэргийн тоо болон оролцогчдын байдлыг судлан авч үзэхэд олон улсын маргаан шийдвэрлэсэн тоо нь цөөхөн, дийлэнх нь дотоодын маргааныг шийдвэрлэсэн дүн гарсан байв (Хавсралт 4). Монголын олон улсын арбитрын цахим хуудаснаа мэдээлснээр 2017-2019 онд хянан 231 хэрэг, 128,7 тэрбум үнийн дүнгийн маргааныг хянан шийдвэрлэсэн байдаг. 2019 оноос хойш өнөөдрийг хүртэл хянан шийдвэрлэж буй хэргийн тоо нэмэгдсэн ч, бусад олон улсын арбитр болон шүүхээр шийдвэрлэж буй хэргийн тоотой харьцуулахад бага хэвээр байна (706 хэрэг хянан шийдвэрлэсэн). Үүнээс 52 нь олон улсын маргаан байна. Тус Олон улсын арбитрын албан ёсны эх сурвалжийг үндэслэхэд 2020, 2021 онд олон улсын маргааны тоо цар тахалтай холбоотойгоор багассан бол дараах жилүүд нь нэмэгдсэн байв.

Өнөөдрийг хүртэл үйлчилж ирсэн МҮХАҮТ-ын дэргэдэх Олон улсын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм нь 2017 оны 3 дугаар сарын 2-ны өдөр Арбитрын тухай хуульд нийцүүлэн батлагдсан юм. Арбитрын тухай хууль мөн л 2017 оны 1 дүгээр сарын 26 онд батлагдсан бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх дүрмийг тус шинэчилсэн хуульд нийцүүлэн баталсан байдаг. Гэвч тус арбитрын ажлын алба, арбитрчид болон зарим судлаачид уг дүрэм нь ЮНСИТРАЛ-ын загварт бүрэн нийцээгүй шинэчлэгдэх шаардлагатай гэж үзээд 2022 оноос эхлэн шинэчлэх ажлыг эхэлсэн байдаг.

Монгол улсын гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын тоо хэмжээ жилээс жилд өсөж байгаа ч Монгол улс дахь арбитрын байгууллагаар олон улсын маргаанаа шийдвэрлэх тоо бага өсөж байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх журмын ялгаатай байдал, олон улс дахь нэр хүнд, чадвар, олон улсад хүлээн зөвшөөрөгдөхтэй холбоотой байж болзошгүй. Иймд Монголын олон улсын арбитр нь сүүлийн 2 жилийн хугацаанд арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмээ шинэчлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор арбитрч болон ажлын албаны төлөөлөгчдөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулж, нэлээд идэвхтэй ажиллаж байгаа.

Тус Ажлын хэсгийн гол зорилго нь арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийг олон улсын стандартад нийцүүлэх бөгөөд загвар болгон Олон улсын худалдааны Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам (ICC), ЮНСИТРАЛ-ын Арбитрын загвар журам, Хонг Конгийн болон бусад хэд хэдэн олон улсын арбитрын холбогдох журмыг харьцуулан судалж, практикт тулгарч байгаа асуудлыг мөн хэлэлцсэн. Гадаадын мэргэжилтнүүд ч мөн Арбитрын холбогдох журамд саналаа өгөөд одоогийн журам нь ойлгоход хүндрэлтэй, олон улсын тухайлбал ЮНСИТРАЛ-ын загвар журмаас ялгаатай байна гэж дүгнэсэн нь журмын шинэчлэл хэрэгтэй байгааг мөн нотолж байна.

ЮНСИТРАЛ-ын 1976 оны загвар журамд арбитрын ажиллагааг эхлүүлэх, арбитрчийг сонгох, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх процесс, хэрэглэх эрх зүйн хэм хэмжээ, шийдвэр ба зардлын талаар зохицуулсан. ЮНСИТРАЛ-ын 2010 оны шинэчилсэн журамд арбитрын бүрэлдэхүүний зарим эрхийг нэмэгдүүлж, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх явцад авах арга хэмжээ, нотлох баримтыг хамгаалах талаар арга хэмжээг зааж өгсөн. Мөн сүүлийн жилүүдэд цахим ажиллагааны талаар зохицуулалтыг нэмж заасан байдаг.

Олон улсын худалдааны арбитр (ICC) дунджаар жилд 1000 хэрэг шийддэг бөгөөд 60 гаруй улсад үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн юм. Сүүлийн 30 жилд мөн Сингапурын арбитр, Хонг Конгийн арбитр, Лондонгийн олон улсын арбитр хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа, түргэн шуурхай байдлаараа мөн олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, нэр хүндтэй болсон. Бусад орнууд ч мөн олон улсын арбитрыг байгуулсан бөгөөд ихэнх арбитрууд журмаа олон улсын стандартад нийцүүлэхийг эрмэлзэх болсон. Мөн түүнчлэн хөдөлмөрийн, спортын, оюуны өмчийн, барилгын, даатгалын, далайн арбитрууд мөн байгуулагдах болсон. 1923 онд Парис хотноо байгуулагдсан Олон улсын худалдааны арбитр арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хэд хэдэн журам, тухайлбал, эвлэрүүлэн зуучлах, шинжээч томилох, арбитрын бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэх, урьдчилсан ажиллагаа журмыг тус тус баталж, журмаа үе үе шинэчилж ирсэн юм. Олон улсын загвар журамд арбитрын байгууллагуудад хандах оролцогчид нэмэгдэж, жилээс жилд нэр хүнд нь өсөж ирсэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх олон улсын арбитрын “Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм” нь зөвхөн олон улсын төдийгүй дотоодын маргаанд үйлчилдэг бөгөөд энэ нь олон улсын маргаанд оролцогчдын шүүмжлэлийг дагуулсаар байгаа. Хэдий уг дүрмийг олон улсын ЮНСИТРАЛ-ын загварт нийцүүлсэн гэж үздэг ч дараах байдлаар бүрэн нийцээгүй гэж дүгнэгдсэн юм.

- Агуулга бүтэц дарааллын хувьд ялгаатай, хууль заасан зарим зохицуулалт нь давхардсан
- ЮНСИТРАЛ-ын журамд хугацаа тоолох, арбитрын ажиллагааны талаар мэдэгдэх талаар зохицуулалтыг эхэнд нь тусгасан бол манай улсын холбогдох дүрэмд харьяаллын асуудал, хэрэглэх эрх зүйн хэм хэмжээний талаар нэлээд дэлгэрэнгүй зохицуулсан нь ЮНСИТРАЛ-ын загвараас ялгаатай байна
- ЮНСИТРАЛ-ын загвар нь мэдэгдэл гаргах, нэхэмжлэлийн агуулга, дагалдах нотлох баримтыг зааж, арбитрчийг томилох, татгалзах гэсэн дарааллаар эхэлж илүү процессын шинжтэй асуудлыг нэн тэргүүнд зохицуулснаараа ялгаатай байна.
- Арбитрын харьяаллын талаар МҮХАҮТ-ын Арбитрын дүрэмд заасан нь дотоодын маргааныг давхар зохицуулдагтай холбоотой байж болзошгүй юм
- Дараагийн нэг асуудал хэрэглэх эрх зүйг журамд дэлгэрэнгүй заасан нь мөн ойлгомжгүй байв, арбитраар хэрэг хянан шийдвэрлэх нэг онцлог нь талууд олон улсын хэлэлцээрт заасны хэрэглэх эрх зүйгээ тодорхойлж болдог, иймд арбитрын бүрэлдэхүүн энэ талаар шийдэж байгаа нь онцлог байв.
- Арбитрын ажиллагааны талаар мэдэгдэх болон хугацаа тоолох талаар ч зарим ялгаатай зүйлүүд байсан.
- Монголын Олон улсын арбитрын дүрэмд нэхэмжлэл гаргах гэж заасан байдаг бол ЮНСИТРАЛ-ын журамд арбитрын ажиллагаа эхлэх явцад мэдэгдэл гаргах гэж заасан байдаг нь арбитрын ажиллагааг эхлүүлэх, үүнд дотор нь нэхэмжлэл гаргах, арбитрчийг томилох, томилох эрх бүхий субъект, нотлох баримтыг хэрхэн хавсаргах илүү өргөн агуулгатай байна.
- Арбитрчийг хэрхэн томилох болон хэдэн арбитрч томилох талаар олон улсын практикт ихэвчлэн талууд гэрээндээ тохирсон эсхүл нэхэмжлэл гаргахдаа талууд заадаг бол манай улсын хувьд арбитрч нарыг жагсаалтаас сонгох, мөн Арбитрын тухай хуульд заасан зарим заалтыг давхардуулж зохицуулсан байна.
- Арбитрын тухай хуульд мөн талуудыг төлөөлөх талаар нарийвчлан зохицуулаагүй, бусад зохицуулалтын хүрээнд авч зохицуулсан нь агуулга бүтцийн болон дарааллын хувьд ЮНСИТРАЛ-ын журмаас арай өөр байв.
- ЮНСИТРАЛ-ын журамд эрх бүхий этгээд арбитрчийг хэрхэн томилох, үүнд нэг арбитрч болон бүрэлдэхүүн хэрхэн томилох талаар дэлгэрэнгүй заасан бол, манай энэ асуудлыг өөр өөр бүлэгт, арай өөр байдлаар зохицуулсан байв.
- Арбитрчийг томилохгүй байх үндэслэл болон татгалзах талаар мөн ЮНСИТРАЛ-ын журамд тусгайлан зохицуулж, хэд хэдэн зүйлд энэ талаар заасан байдаг. Талууд эсхүл арбитрч татгалзлыг зөвшөөрөөгүй нөхцөлд эрх бүхий байгууллага уг асуудлыг шийдэж болох талаар мөн заасан. Монголын холбогдох дүрэмд энэ талаар заасан бөгөөд зарчмын хувьд нийцсэн боловч ялгаатай зохицуулалт мөн байсан.
- ЮНСИТРАЛ-ын өөр нэг анхаарах зохицуулалт нь талууд арбитрын эсрэг нэхэмжлэл гаргаж, хариуцлага хүлээлгэхгүй байх талаар заасан байдаг.
- Монголын Олон улсын Арбитрын дүрэмд мөн арбитрчийг нөхөн томилох нөхцөл болон зохицуулалт нь ЮНСИТРАЛ-ын дүрмээс ялгаатай байна. Жишээ нь Арбитрын дарга арбитрчийг чөлөөлөх заасан нь олон улсын жишгээс ялгаатай байв.
- Дээр дурдсанаар ЮНСИТРАЛ-ын журам нь арбитрын ажиллагааг эхлүүлэхээс шийдвэр гаргах хүртэл үе шаттайгаар зохицуулаад, энэ бүх шатны явцад гарах асуудлыг журамласан байдаг. Үүнтэй холбогдуулан манай улсын дүрэм дараалал, бүтцийн хувьд ЮНСИТРАЛ-аас ялгаатай байв. Зарим зүйлийг маш дэлгэрэнгүй, зарим зүйлийг өөрөөр зохицуулсан байх жишээтэй.
- Жишээ нь арбитрчийг томилсны дараа арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулж, үүнд арбитрын ажиллагааны зарчим, хуралдааны газар, хэл, талуудын холбогдох баримт бичгийг хэрхэн хүргүүлэх, гуравдагч этгээд оролцуулах талаар зохицуулсан
- ЮНСИТРАЛ-д ялгаатай арбитрын ажиллагааг мэдэгдэх болон нэхэмжлэлийг тусад нь заасан байдаг. Ингэхдээ нэхэмжлэл гаргах хугацаа болон хариу тайлбар ирүүлэх талаар арбитрын шүүх хугацаа зааж өгөх боломжтой юм.
- Арбитрын харьяаллын талаар арбитрын шүүхийн эрх хэмжээний талаар зохицуулалт ЮНСИТРАЛ-ын зохицуулалттай нийцсэн байв.
- Арбитрын дүрэмд арбитрын ажиллагаа явуулах журмыг хэрхэн тогтоох талаар зохицуулсан нь ЮНСИТРАЛ-ын журмаас ялгаатай байв.
- Арбитрын дүрэмд мөн талуудын тэгш эрхийн талаар зохицуулалтыг заасан нь ЮНСИТРАЛ-аас ялгаатай байв. Энэ нь манай улсын өөрийн зохицуулалт, онцлогтой холбоотой байж болох юм.

- Нотлох баримт, гэрч оролцуулах, шинжээч томилох талаар Арбитрын журамд заасан боловч зарим зохицуулалт нь ЮНСИТРАЛ-ын зохицуулалтаас ялгаатай, зарим нь ЮНСИТРАЛ-аас илүү дэлгэрэнгүй заагдсан байх жишээтэй.
- Арбитрын дүрэм нь зарим талаасаа маш дэлгэрэнгүй зохицуулсан нь талуудын эрх, Арбитрын шүүхийн эрх хэмжээг нарийн зохицуулж, зарим үйлдлийг шууд зааж өгсөн, зарим нөхцөлд хязгаарласан агуулгатай байна гэж дүгнэгдсэн
- Өөр ийм төрлийн олон ялгаатай зохицуулалт мөн агуулагдсан байна. Жишээ нь тэмдэглэлийн талаар нарийн зохицуулсан нь мөн дотоодын арбитрын өөрийн онцлогтой холбоотой байж болзошгүй.

Дээр дурдсанаар Монгол улс дахь хамгийн урт удаан түүхтэй Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон улсын арбитрын одоогийн үйлчилж байгаа хэрэг хянан шийдвэрлэх дүрэм нь олон улсын стандартад нийцэхгүй зарим зүйл байгаа учир олон улсын арбитрын стандартад нийцүүлэх шаардлага байгаа нь илэрхий байна. Олон улсын арбитрыг дэргэд байгуулсан ажлын хэсэг энэ асуудлыг анхаарч Олон улсын стандартад нийцүүлэх шаардлагатай гэж үзэж холбогдох ажлыг эхлүүлсэн байгаа. Мөн дотоодын маргаан болон олон улсын маргаанд хэрэглэх журмыг зааглах нь зүйтэй гэж шийдсэн болно.

МҮХАҮТ-ын дэргэдэх Олон улсын арбитр нь Монгол улсдаа арбитрын хэрэг хянан шийдвэрлэсэн тоо болон ажилласан жилээр бусад арбитрын хувьд илүү, туршлагатай гэж үнэлэгдсэн. Тус арбитрт хандаж, хянан шийдвэрлэсэн хэрэг, тоо, тулгамдсан асуудал болон бусад мэдээллийн талаар хандаж, фокус ярилцлага хийсэн. Хянан шийдвэрлэсэн хэргийн талаар мэдээллийг энэхүү тайланд хавсаргасан болно.

Б. Барилгын арбитр

Барилгачдын холбооны Ерөнхийлөгчийн захирамжаар 2006 онд **Барилгын арбитр** байгуулагдсан байна. 2007 онд Тус арбитр нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүрмээ баталсан байна.

Барилгын арбитрын дүрмийг харахад мөн олон улсын жишгээс ялгаатай, жишээ нь хэрэглэх эх сурвалжид ЮНСИТРАЛ-ын журам болон Үндэсний арбитрын дүрмийг хэрэглэнэ гэж заасан байв. Мөн бусад зохицуулалтыг нь судлан үзэхэд зарим зохицуулалт нь арбитрын хуульд нийцсэн ч зарим нь агуулгын хувьд хуулийн холбогдох зохицуулалтаас арай өөр утгаар илэрхийлэгдсэн байв.

Жишээ нь тус журмын 7 дахь заалт “ТАЛУУД ҮҮРГЭЭ ҮЛ БИЕЛҮҮЛЭХЭЭС ҮҮСЭХ ҮР ДАГАВАР”-д “Аль нэг тал нь арбитрын хуралд оролцоогүй, эсвэл арбитрт шаардлагатай нотлох баримт ирүүлээгүй бол арбитрын ажиллагааг арбитрч үргэлжлүүлэх, ирүүлсэн нотлох баримтад үндэслэж арбитрын шийдвэр гаргана”. Мөн үг үсгийн алдаа олон байсан нь программын алдаатай холбоотой байсан боловч уу гэж дүгнэгдсэн. Барилгын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам нь нэрээс нь үндэслэхэд барилгын холбоотой маргааныг шийдвэрлэх зорилготой боловч үйлчлэх хүрээг нарийн тодорхойлоогүй байх жишээтэй.

Барилгын арбитртай холбоо барьж хууль хэрэгжилт, тулгамдсан асуудлын талаар судалгаа авах гэсэн боловч тус арбитрын үйл ажиллагаа нь зогсонги, мэдээлэл авч чадаагүй.

В. Улаанбаатар хотын худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх олон улсын арилжааны арбитр

Улаанбаатар хотын худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх олон улсын арилжааны арбитр мөн байгуулагдаад нэлээд хэдэн жил болсон юм. Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын дараа Монгол улс дахь туршлагатай олон жил ажилласан арбитрын нэг хэлж болно. Уг Арбитрын Дүрэм нь 2022 онд шинэчлэгдэн батлагдаж, дүрэмд зааснаар нь тус арбитрын зорилго нь эдийн засаг болон бизнесийн иргэний эрх зүйн маргааныг шийдвэрлэнэ гэжээ. Анх 2015 онд байгуулагдсан Үндэсний ба олон улсын арилжааны арбитр нь дотоодын ба олон улсын маргааныг шийдвэрлэх эрх хэмжээг заасан байна. Тус байгууллагын цахим хуудас дээр байршуулсан танилцуулга дээр

- Гэрээнээс үүссэн аливаа маргаан
- Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан
- Эд хөрөнгийн маргааныг тус тус шийдвэрлэхээр заасан байв.

Тус байгууллага нь арбитрын үйл ажиллагаатай холбоотой 6 дүрэм журам баталсан байсан бөгөөд эдгээрээс хэрэг хянан шийдвэрлэх журмыг онцлон судалсан. Уг журам нь 2022 онд шинэчлэгдэн батлагдсан бөгөөд агуулгыг харахад Арбитрын тухай хууль ба олон улсын жишигт нийцүүлэх талаас

нь мөн нэлээд анхаарсан байв. Энэ журамд харьяалагдах маргаан, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаатай холбоотой үе шатыг мөн зааж өгсөн байна. Агуулгын хувьд дүгнэхэд зарим зохицуулалт нь ЮНСИТРАЛ-ын загвар журамд нийцсэн бол зарим нь Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Олон улсын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн адил өөрийн онцлог зохицуулалтыг мөн агуулсан байв.

Журамд мөн ИХШХТХ-ийг хэд хэдэн удаа эшилж (Журмын 6.4), зарим зохицуулалтыг ийнхүү холбосон нь зарим талаар арбитрын үйл ажиллагаанд ИХШХТХ-аар зохицуулсан онцлогтой болон олон улсын журмын ялгаатай байв. Зарим зохицуулалтыг мөн авч үзэхэд илүү санаачилгатай, олон улсын зохицуулалтаас арай дэлгэрэнгүй байдлаар зохицуулсан нь тухайн байгууллагын онцлогтой байж болзошгүй. Нэмж хэлэхэд мөн МҮХАҮТ-ын дэргэдэх Олон улсын арбитрын дүрмийн зарим зохицуулалттай адил олон улсын болон дотоодын маргааныг зохицуулах журмыг зааглаагүй, зарим зохицуулалт нь дотоодын маргаанд зориулагдсан байна гэж үнэлэгдсэн. Анхаарах нэг зүйл нь зарим зохицуулалт нь Арбитрын тухай хуулиар зохицуулсан зүйлийг давхардуулсан, олон улсын жишгээс арай өөрөөр зохицуулсан, арбитрын бүрэлдэхүүний эрх хэмжээ, талуудын эрхийг шууд журамласан нь арбитрын үйл ажиллагааны шүүхээс ялгаатай онцлогийг бууруулах үр нөлөөтэй байна гэж дүгнэгдсэн. Тус арбитрын албан ёсны эх сурвалжийг үндэслэхэд байгуулагдсан цагаасаа эхлээд 21 хэргийг хянан шийдвэрлэсэн байв.

Улаанбаатарын арбитрын онцлог нэг зүйл нь ЮНСИТРАЛ-ын жишгийг дагаад хянан шийдвэрлэх үйл ажиллагааг хэд хэдэн журмаар, тухайлбал эвлэрүүлэх, түргэвчилсэн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулахыг зорьсон байв.

Г. Спортын арбитр

Спортын арбитр мөн сүүлийн үед идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй арбитрын нэг юм. Монгол Улсад төрөлжсөн арбитр, тухайлбал барилгын, хөдөлмөрийн арбитр, спортын арбитр байна гэсэн мэдээлэл нийтэд гарсан боловч, бодитоор үйл ажиллагаа явуулж буй гол арбитрын нэг нь спортын арбитр байгаад байна.

Спортын арбитрын онцлог нь Олон улсын Олимпын хороо болон мэргэжлийн холбооны дүрэм, журмыг үндэслэж үйл ажиллагаагаа явуулдаг байв. Бүтцийн хувьд Монголын Олон улсын ба үндэсний спортын арбитр нь давж заалдах комисс, эвлэрүүлэн зуучлах төв, ажлын алба гэсэн бүтэцтэй байна. Уг арбитр нь Арбитрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасныг үндэслэн байгуулагдсан байв. Бусад арбитраас уг арбитрын ялгагдах гол онцлог нь бизнесийн маргаан эсхүл эд хөрөнгийн харилцаанаас үүсэх маргааныг шийдвэрлэх бус спортын тэмцээн, арга хэмжээнд оролцогчдын маргааныг харьяалан шийддэг нь спортын дүрэм болон бусад холбогдох эх сурвалжийг хэрэглэдэг, мөн үүнээс гадна Олон улсын спортын мэргэжлийн хорооны дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Зарим тохиолдолд, жишээ Допингийн давж заалдах комисст Допингийн эсрэг дүрмийн зүйл заалттай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх эрх хэмжээтэй бөгөөд тус комиссоос гарсан шийдвэрийг Олон улсын спортын арбитрын шүүхэд давж заалдаг байх нь арбитрын үйл ажиллагааны сонгодог зохицуулалтаас ялгаатай байв. Уг арбитр нь байгуулагдсан үеэсээ эхлэн 9 орчим хэргийг хянан шийдвэрлэжээ.

Спортын арбитр өөрийн гэсэн онцлогтой илүү тэмцээний үед үүссэн болон тэмцээнд оролцогчид дүрэм журмын дагуу явуулсан эсэх маргааныг хянан шийдвэрлэдэг учраас хэрэглэх эх сурвалж нь ялгаатай, илүү олон улсын спортын дүрэм журмыг хэрэглэх онцлогтой. Тус арбитрын эрх бүхий төлөөлөгчидтэй хийсэн фокус ярилцлагыг үндэслэхэд спортын арбитрын дүрэм журам нь Олон улсын спортын арбитрын шүүхийн дүрэм, Спортын салбарын хууль (Биеийн тамир, спортын тухай хууль, 2024 он) үндэслэгдэх тул бусад арбитраас ялгаатай байна. Тус арбитраас ирүүлсэн судалгаа болон салбарын эрх зүйн баримт бичгийг судлахад Спортын арбитрын үйл ажиллагааг Арбитрын тухай хуулиар нийтлэг байдлаар зохицуулах боломжгүй гэж дүгнэгдсэн. Өөрөөр хэлбэр нэг бол тусдаа салбарын хуулиар нь зохицуулж, үүнд ИХШХТХ-аар энэ талаар тусгайлан зохицуулалтыг тусгах, нэг бол Арбитрын тухай хуульд нь спортын арбитрын үйл ажиллагааны талаар тусгайлан зохицуулалт хийж болохоор байна.

Д. Хөдөлмөрийн арбитр

Хөдөлмөрийн арбитрын дүрэм нь Засгийн газрын 2023 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн тогтоолын Хавсралтаар батлагдсан юм. Хөдөлмөрийн арбитр нь хөдөлмөрийн сонирхлын маргааныг хянан шийдвэрлэх эрх хэмжээтэй. Бусад арбитраас ялгаатай нь маргалдагч тал нь Хөдөлмөрийн тухай хуулийн

151.1-т заасны дагуу тухайн шатны гурван талт хороонд арбитраар шийдвэрлүүлэх хүсэлтээ гаргана. Тус хороо нь арбитрын бүрэлдэхүүнийг томилохоор заасан байдаг. Талууд тухайн бүрэлдэхүүнийг татгалзах эрхгүй гэж тус дүрмийн 2.3.-т заасан нь Арбитрын үйл ажиллагааны сонгодог зохицуулалтаас ялгаатай байна.

Салбарын онцлог байгаа ч хөдөлмөрийн арбитр нь үйл ажиллагаагаа Арбитрын тухай хуульд нийцүүлэх ёстой гэж үзвэл, арбитрч томилох, татгалзах, хянан шийдвэрлэх журам нь тус хуульд нийцсэн байх ёстой.

Жишээ нь Хөдөлмөрийн арбитр нь бусад арбитраудаас ялгаатай хэд хэдэн зүйл байсан, жишээ нь нэгт бүрэлдэхүүнийг томилох эрх бүхий субъектийг заасан, хоёрт, хэрэг хянан шийдвэрлэх хугацаа арай богино, процессын хувьд ч ялгаатай байв. Арбитрын шийдвэр нь эцсийн байхаар зааж, талууд процессын журам зөрчсөн нөхцөлд шүүхэд давж заалдахаар заасан байдаг. Тус Дүрмийн 4.5-д нь арбитрын шийдвэр нь эцсийн байх бөгөөд хэрэг хянаж шийдвэрлэх журмыг зөрснөөс бусад тохиолдолд шүүхэд гомдол гаргахгүй гэж заасан байв. Шүүхэд гомдол гаргах нөхцөлд шүүх Арбитрын тухай хуулийг үндэслэж тухайн арбитрын үйл ажиллагааны журмын холбоотой маргааныг шийдвэрлэх тул энэ арбитрын дүрмийг хуульд нийцүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт

Монгол Улсад байнгын арбитрын үйл ажиллагаа явуулж буй хэд хэдэн арбитрын дүрмийг судлан авч үзэхэд “зорилгодоо хүрсэн” болон “практикт нийцэж буй байдлын” талаар дараах дүгнэлтийг гаргалаа.

1. Монгол Улсад Арбитрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг болон 7 дугаар зүйлд заасны дагуу хэд хэдэн арбитрын байгууллага байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байна. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэж буй тоог үндэслэхэд жилээс жилд арбитрт хандах иргэд, хуулийн этгээдийн тоо нэмэгдсээр байна (Хавсралт 4). Харин байнгын бус арбитраар хэргээ хянан шийдвэрлүүлэх практикт Монголд харьцангуй бага байна.
2. МҮХАҮТ-ын дэргэдэх Олон улсын арбитр ба Улаанбаатар хотын арбитрын Үндэсний ба олон улсын арилжааны арбитрт олон улсын хэрэг хянан шийдвэрлэж буй тоо бага хэвээр байна.
3. Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх олон улсын арбитр, Улаанбаатар хотын олон улсын арбитр нь олон улсын ба дотоодын маргааныг хянан шийдвэрлэх эрх хэмжээтэй байж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам нь аль аль харилцаанд хамаарахаар заасан байв. Хэдий олон улсын хэрэг маргааныг шийдэхээр заасан ч олон улсын жишиг, ЮНСИТРАЛ -ын загвар дүрмээс ялгаатай байв.
4. Бусад төрөлжсөн арбитрауд болох Спортын арбитр, Хөдөлмөрийн арбитр, Барилгын арбитр нь харьяалагдах хэргийг зааж, салбарын онцлогийг зохицуулахыг зорьсон байна. Эдгээр арбитр нь салбарын холбогдох харилцааг зохицуулах чиг үүрэгтэй, дотоодын маргааныг хянан шийдвэрлэх тул, дүрэм журам нь өөрийн салбарын онцлогтой байхыг үгүйсгэхгүй юм. Эдгээр арбитрын зохицуулалтын зарим нь Арбитрын тухай хуулийг зөрчсөн, үйл ажиллагаа нь арбитрын ажиллагааны онцлогийг хэрэгжүүлээгүй байв.
5. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх арбитр нь 2017 оны Арбитрын тухай хуульд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах бөгөөд арбитрын хүлээн зөвшөөрөх болон биелүүлэхэд шүүх Арбитрын тухай хуулийг гол нь баримтална шийдвэр гаргах тул, Арбитрын холбогдох журам болон дүрэм нь хуульд нийцэх шаардлагатай байна.

2.4 Арбитр ба шүүхийн оролцоо

А. ЮНСИТРАЛ-ын Загвар хууль ба дотоодын хуульд зохицуулсан байдал

Үнэлгээ хийхээр сонгосон заалт

№	Үнэлгээний шалгуур	Сонгосон зүйл заалт
1	Зорилгод хүрсэн түвшин	Арбитрын тухай хууль 6 дугаар зүйл.Шүүхийн оролцоо 6.1.Шүүх энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд арбитрын ажиллагаанд оролцож үл болно. 6.2.Энэ хуулийн 11.1, 13.4, 13.5, 15.3, 16.1, 18.7, 39.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлд заасан шүүхийн чиг үүргийг арбитрын ажиллагаа явагдсан газрын иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, харин олон улсын арбитрын ажиллагааны хувьд нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хэрэгжүүлнэ. 6.3.Энэ хуулийн 27, 29, 48, 51 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хариуцагчийн оршин суугаа газрын, эсхүл түүний эд хөрөнгө нь байгаа газрын иргэний хэргийн анхан шатны шүүх хэрэгжүүлнэ
2	Практикт нийцэж байгаа байдал	ЮНСИТРАЛ-ын Загвар хуулийн зохицуулалттай нийцсэн. Иргэд болон хуулийн этгээд нь шүүхэд хандаж тусламж авах болон арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх талаар өргөдөл гомдол гаргах практик нэмэгдэж байгаа Арбитрын тухай хуульд заасан түр арга хэмжээг хэрэгжүүлж буй практик маш бага байна

Хэдий арбитрын байгууллага нь шүүхээс хараат бус болон бие даасан байгууллага ч төрөөс зарим нөхцөлд тусламж авах шаардлага гардаг. Арбитрын ажиллагаатай холбоотой асуудал, жишээ нь арбитрчийг томилох, арбитрын харьяалал тогтоох, нотлох баримт цуглуулах, хамгаалах, арбитрын шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авах, арбитрын шийдвэрийг албадан биелүүлэх нөхцөлд хуульд заасан эрх бүхий байгууллагын, шүүхийн туслалцаа авах шаардлага гардаг.

Ихэнх улсын хуульд шүүх нь хүний эрхийг хамгаалах, хууль сахиулах онцгой эрх хэмжээтэй байдгийн хувьд албадан арга хэмжээ авах, шийдвэрээ биелүүлэх механизмтай билээ. Арбитрын ажиллагаанд шүүх оролцож болохгүй гэж үздэг хэсэг хүмүүс байдаг ч байнгын болон байнгын бус арбитрын хувьд өөрийн шийдвэрээ хэрэгжүүлэх, талууд болон арбитр өөрөө шийдэж чадахгүй маргаан, асуудлыг хөндлөнгийн байгууллагаар шийдүүлдэг бөгөөд энэ үүргийг хэрэгжүүлж чадах байгууллага нь шүүх гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаг.

ЮНСИТРАЛ-ын 1986 оны загвар хууль болон түүний нэмэлт өөрчлөлттэй 2010 оны загвар хуульд мөн шүүхийн оролцооны талаар заасан байдаг. Энэ жишгийн адил Арбитрын тухай Монгол улсын хуульд мөн шүүх хэдийд хэрхэн оролцох талаар зохицуулсан байна. Тухайлбал, Арбитрын тухай хуулийн 6 дугаар зүйлд шүүх хэрхэн оролцох болон аль шатны шүүх оролцох талаар тодорхой заасан нь арбитрын ажиллагааг бие даан явуулах, шүүхийн оролцоог хязгаарлах зорилготой юм. ЮНСИТРАЛ-ын Загвар хууль болон Арбитрын тухай хуульд зааснаар шүүх дараах нөхцөлд арбитрын ажиллагаанд оролцдог. Үүнд,

- Харьяаллын асуудлаар маргааныг шийдэх,
- Арбитраас гарах шийдвэрийг баталгаажуулах,

- Арбитрчийг томилох талаар шүүх эсхүл эрх бүхий байгууллага шийдэх ,
- Арбитрчийг татгалзан гаргах талаар гомдлыг хянан шийдвэрлэх,
- Хуульд заасны дагуу түр арга хэмжээг биелүүлэхээр шүүхэд хандах,
- Түр арга хэмжээг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзах шийдвэр гаргах,
- Нотлох баримт бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх,
- Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу талууд арбитрын үндэс шийдвэрийн талаар шүүхэд хүчингүй болгуулах талаар өргөдөл гаргах,
- Шүүх арбитрын ажиллагааны талаар журам зөрчсөн талаар өргөдлийг хүлээн авч арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, эсхүл биелүүлэхээс татгалзах

Сүүлийн жилүүдэд иргэд болон хуулийн этгээд нь Монгол улс дахь Олон улсын арбитрт хандах тоо нэмэгдэж, талууд, тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нар арбитрын ажиллагааг журмын дагуу явуулах талаар анхаарах болсон. Энэ хүрээнд ч холбогдох тал нь арбитрын журам зөрчсөн, шийдвэрийг хүчин төгөлдөр бусаар тооцуулах талаар шүүхэд хандах хандлага нэмэгдсэн. Зарим тохиолдолд давж заалдах ёстой гэсэн үндэслэлийн хүрээнд мөн шүүхэд хандах ч тохиолдол бий (Хавсралт 2, 3). Шүүхэд хандаж арбитрын шийдвэрийг хүчингүй болгох өргөдөл гаргаж байгаа нь хоёр талтай байж болно, нэгт талууд болон тэдний төлөөлөгчид арбитрын ажиллагааг сайн мэддэг болж, журмыг зөрчсөн нөхцөлд үүнийг нь эсэргүүцэж, хоёрт талууд ажиллагааг сайн мэддэг ч хугацаа хожих, давж заалдах боломжийг ашиглах юм.

Дээр дурдсанаар арбитрын ажиллагаатай холбоотойгоор хоёр нөхцөлд хандаж болохоор харагдаж байна, нэгт арбитрын ажиллагааг хэрэгжүүлэх, шүүхээс тусламж авах тохиолдолд, хоёрт арбитрын шийдвэрийг давж заалдах юм. Эхний тохиолдолд шүүх хуульд заасан эрх мэдлээ урвуулан ашиглах тохиолдол харьцангуй бага болов уу, харин хоёр дахь нөхцөлд өөрт нь тааламжгүй арбитрын шийдвэрийг давж заалдах тохиолдол гарахыг үгүйсгэхгүй. Хоёр дахь нөхцөлд арбитрын үйл ажиллагаанд шүүх эрх мэдлээ урвуулан ашиглахыг үгүйсгэх, шүүхийн оролцоог зөвхөн хуульд заасан үндэслэлээр хэрэгжүүлэх нь чухал юм.

Эрдэмтдийн бүтээлд шүүх арбитрын ажиллагаанд оролцох талаар авч үзэхдээ гадаадын шүүх ба дотоодын шүүх гэж ангилсан байдаг. Арбитрын суудлын нутаг дэвсгэрт шүүх оролцох нөхцөлд дотоодын шүүхийн талаар ярьдаг, харин арбитрын үйл ажиллагаа явуулж байгаа газар нь суудлын газраас ялгаатай нөхцөлд шүүх оролцох тохиолдолд гадаадын шүүхийн талаар ярьдаг гэжээ.

Арбитрын ажиллагааны явцад шүүх оролцож, аль нэг талын гомдлын дагуу арбитрын ажиллагааг түдгэлзүүлэх нь арбитрын ажиллагааг хэт их удаашруулах эрсдэлтэй гэж үздэг тул ЮНСИТРАЛ-ын Загвар хуулийн 16 дугаар зүйлд арбитрын хэлэлцээрийн хүчин төгөлдөр болон хэлэлцээр хийгдсэн талаар гомдлыг аль нэг тал нь шүүх эсхүл эрх бүхий байгууллагад гаргах эрхтэй ч арбитр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхгүйгээр үргэлжлүүлэх эрхтэй байдаг.

Монголын шүүхийн практик болон арбитрын шийдвэрийн хэрэгжилтийн талаар энэ хэсэгт авч үзсэн бөгөөд Арбитрын тухай хуульд зааснаар Анхан шатны шүүх болон давж заалдах шатны шүүх арбитрын ажиллагаанд оролцдог. Анхан шатны шүүх арбитрын шийдвэрийг баталгаажуулах, татгалзах, Арбитрын харьяалалд шилжүүлэх эрхтэй байна. Давж заалдах шатны шүүх арбитрын ажиллагаатай бусад асуудлаар оролцдог.

Холбогдох заалтыг үндэслэвэл Давж заалдах шүүх дараах байдлаар шийдвэр гаргах эрх хэмжээтэй :

- Арбитрын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 болон 13.5 дахь хэсэгт зааснаар арбитрчийг томилох,
- Мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт зааснаар Арбитрчийг татгалзан гаргах хүсэлт шийдвэрлэх
- Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дахь хэсэгт зааснаар Арбитрчийн эрх, үүргийг дуусгавар болгох
- Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэгт зааснаар Маргааны харьяалал тогтоох
- Мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт зааснаар Нотлох баримт бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх
- Арбитрын тухай хуулийн 47 зүйлд зааснаар Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох
- Арбитраас гарах шийдвэрийг баталгаажуулах

Анхан шатны шүүх доорх нөхцөлд зааснаар шийдвэр гаргах эрх хэмжээтэй байна:

- Арбитрын тухай хуулийн 27 дугаар зүйл, 29 дугаар зүйлд заасны дагуу “Түр арга хэмжээ авах”,
- Мөн хуулийн 48 дугаар зүйлд зааснаар “Арбитрын үндсэн шийдвэрийг гүйцэтгэх, татгалзах”,
- Хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу “Дампуурлын маргааныг арбитрт шилжүүлэх.”

2015 оноос 2018 онд шийдсэн хэргийн судалгааг харахад, Шүүх 2015 онд 6 удаа, 2016 он 10 удаа, 2017 онд 24, 2018 онд 20 удаа арбитрын ажиллагаатай холбоотой шийдвэр гаргасан байна. Мөн судалгаанд үндэслэхэд Арбитрын шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдол 2015 онд 2, 2016 онд 3, 2017 онд 5, 2018 онд 10 шийдвэр гарсан байна. Эдгээрээс Арбитрын хэлэлцээрт хамаараагүй болон нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй асуудлаар шийдвэр гаргасан, талуудын тохиролцсон журмыг арбитр зөрчиж шийдвэр гаргасан, арбитрын ажиллагааны талаар зохих ёсоор мэдэгдээгүй, хэргийн материал болон нотлох баримтыг танилцуулаагүй, нэмэлт тайлбар гаргах, шүүхэд биечлэн оролцох хүсэлтийг шийдэх, арбитрын харьяаллын биш байсан, төлөөлөх эрхгүй этгээдийн оролцоотой хэрэг шийдсэн гэжээ.

1. Дүгнэлт

2. Монгол Улсын Арбитрын тухай хууль нь ЮНСИТРАЛ-ын загвар хуульд нийцүүлэн шүүхийн оролцоог зааглаж, ямар нөхцөлд сонирхогч тал шүүхэд хандах талаар нь зохицуулсан нь тодорхой хэмжээнд зорилгодоо нийцсэн байна.
3. Монгол Улсын Арбитрын тухай хууль болон ЮНСИТРАЛ-ын Арбитрын Загвар хууль шүүх арбитрын ажиллагаанд хэрхэн оролцох, ямар нөхцөлд оролцож болох талаар зохицуулалт нь хоорондоо нийцсэн байв.
4. Загвар хууль болон АтХ нэг ялгаатай зүйл нь эрх бүхий этгээд болон шүүхийн аль нэгээр заасан асуудлаар шийдүүлэх эрхийг олгосон байна. Байнгын Арбитрын байгууллагууд дүрэмдээ шүүхийн оролцоог багасгах зорилгоор байнгын арбитр тухайн холбогдох асуудлыг хэрхэн шийдэж болох талаар зохицуулж болно. Өнөө үед үйлчилж байгаа дүрэмд шүүхээр шийдүүлэх хандлага нь ажиглагдсан.
5. Зарим байнгын арбитрын шийдвэрийг шүүхээр хэрэгжүүлэхэд хүндрэл гарч болзошгүй, АтХ-ийн 47 дугаар зүйлд заасан үндэслэл байж болно.
6. Практикт нийцсэн байдлын талаар үнэлгээ өгөх зорилгоор энэ судалгааны хүрээнд хэрэглэсэн статистик тоог үндэслэхэд Арбитрын ажиллагаатай холбоотой тусламж авахаар шүүхэд хандах нь цөөн, харин шийдвэрийг давж заалдах нь нэмэгдэх хандлагатай байна.

Зөвлөмж

1. Арбитрын ажиллагаанд тусламж авах болон давж заалдах үйл ажиллагааг тусад нь зохицуулж, аль байгууллагад хандаж шийдэхийг нь ялган заах
2. Шүүхийн оролцооны талаар сургалт зохион байгуулах
3. арбитрын ажиллагааг өөрөө шууд хэрэгжүүлэх талаар, тухайлбал нотлох баримт цуглуулах, түр арга хэмжээ авах талаар зохицуулалтыг хуульд тусгаж өгөх

2.5 Арбитрчийн мэргэжлийн ур чадвар ба ёс зүйн асуудал

Арбитрын үйл ажиллагааг үр дүнтэй, мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэхэд арбитрчийн мэргэжлийн ур чадвар ба ёс зүйн асуудал чухал үүрэг гүйцэтгэдэг. Арбитрын ажиллагаа нь хууль болон журмын дагуу хэрэгжсэн ч арбитрч арбитрын ажиллагааны онцлог, шүүхээс ялгагдах байдлыг харгалзахгүй шийдэх болон ёс зүйн зөрчил гаргах нь бүхэлд нь ажиллагааг үгүйсгэхэд хүргэнэ.

Олон улсын арбитрын байгууллагууд арбитрчийн ур чадвар болон ёс зүйн шаардлага тогтоож, зарим тохиолдолд журам боловсруулсан байдаг. Байнгын үйл ажиллагаа явуулдаг арбитрт харьяалагддаг арбитрчид мэргэжлийн ур чадвар сайтай, өндөр ёс суртахуунтай байх нь тухайн байнгын арбитрын үйл ажиллагаа, нэр хүндэд ихээхэн нөлөөлнө.

Ийм ч учраас арбитрын байгууллагууд өөрийн арбитртаа туршлагатай, өндөр мэдлэгтэй арбитрчийг ажиллуулахыг зорьдог. Арбитрын тухай хууль нь хэдий зорилгодоо хүрсэн, олон улсын стандартад нийцсэн ч түүнийг хэрэгжүүлж буй арбитрчийн ур чадвар болон ёс зүйн зөрчил нь арбитрын үйл ажиллагааг үр дүнгүй болгож, арбитрын тухай хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлнө.

А. Арбитрчийн мэргэжлийн ур чадварт тавигдах шаардлага, хэрэгжилт

Үнэлгээ хийхээр сонгосон заалт

1	Зорилгод хүрсэн түвшин	13 дугаар зүйл.Арбитрчийг томилох журам 13.1. Талууд дараах шаардлагыг хангасан этгээдийг арбитрчаар томилж болно: 13.1.1. талуудын харилцан тохиролцож тогтоосон мэргэжил, ур чадварын тусгай шаардлагад нийцсэн; 13.1.2. хараат бус, бие даасан байх; 13.1.3. өөр ажил, албан тушаал хавсран эрхлэхийг хориглосон хуулийн шаардлагыг зөрчөөгүй байх. 13.2. Талууд өөрөөр тохиролцоогүй бол хэнийг ч иргэний харьяаллаас нь шалтгаалж арбитрчаар томилохоос татгалзаж болохгүй. 13.3. Талууд энэ хуулийн 13.5, 13.6, 13.7, 13.8-д зааснаас бусад тохиолдолд арбитрчийг томилох журмыг харилцан тохиролцож тогтоох эрхтэй.
2	Практикт нийцэж байгаа байдал	Арбитрын байгууллагууд дүрэмд заасны дагуу арбитрч нараа сонгон шалгаруулж жагсаалтдаа бүртгэдэг байна.

Арбитрчийн мэргэжлийн ур чадвар гэдэгт арбитрын үйл ажиллагааны онцлогийн талаар мэдлэгтэй, ажиллагааг хууль журмын дагуу зөв хэрэгжүүлэх, арга хэмжээг зохистой авах, арбитрын хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэглэгдэх эх сурвалж, олон улсын эрх зүйн эх сурвалжийн талаар мэдлэгтэй байхыг хэлж болох юм.

Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх олон улсын арбитрт 2024 оны байдлаар арбитрын цахим хуудасны мэдээллийг үндэслэхэд 62 арбитрч ажиллаж байна. Эдгээр арбитрчийн 51 дотоод, 11 нь гадаадын иргэн байна. Арбитрчийн мэргэжлийн ур чадварын гол үзүүлэлт нь тухайн арбитрын нэр хүнд болон арбитрын ажиллагаатай холбоотой шүүхэд болон эрх бүхий байгууллагад гомдол гаргасан байдал байж болно. Манай улсын практикаас болон өмнөх бүлэгт танилцуулсан шүүхийн судалгааны дүнгээс харахад арбитрын хууль болон журмыг буруу хэрэглэсэн, арбитрын ажиллагааны журмыг зөрчсөн тохиолдол багагүй байна.

Танхимын дэргэдэх арбитр нь арбитрч нараа мэргэшүүлэх, сургах үйл ажиллагааг тогтмол хийж ирсэн бөгөөд жилд 2 удаа олон улсын мэргэжилтнүүдийг урьж авчирч сургалт зохион байгуулсан байна. Жишээ нь АНУ-ын Худалдааны яамны санхүүжилттэйгээр 2023 оны 12 сард, 2024 оны 4 сард арбитрын үйл ажиллагааны талаар сургалтыг зохион байгуулж, арбитрч нараа хамруулсан байна.

Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон улсын арбитрын дүрэмд зааснаар арбитрч нарын жагсаалтыг Танхимын удирдах зөвлөлөөр баталдаг. Тус дүрмийн 3.2.1- дэх заалтад салбартаа мэргэшсэн, хүлээн зөвшөөрөгдсөн байх шаардлагыг тавьсан байв. Арбитрчийг сонгон шалгаруулахдаа

дүрэмд заасан шаардлагыг үндэслэж, Танхимын удирдах зөвлөлөөр хэлэлцэж шийддэг онцлогтой байна.

Улс тус бүр өөрийн хууль эсхүл дүрэмдээ арбитрчид тавих шаардлагаа зааж өгсөн байдаг. Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх олон улсын арбитрын дүрмийн 3.2-т арбитрч нар орон тооны бус байх, өөрийн мэргэжлийн салбартаа мэргэшсэн, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн, ял эдлээгүй, ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй, өөрийн ажилд нь арбитрчаар ажиллах нь харшлахгүй байх гэж заасан байдаг. Бусад арбитрын дүрэмд мөн ийнхүү заасан байх жишээтэй.

Б. Ёс зүйн шаардлага ба дотоодын практик

Үнэлгээ хийхээр сонгосон заалт

1	Зорилгод хүрсэн түвшин	14 дүгээр зүйл.Арбитрчийг татгалзан гаргах үндэслэл 14.1.Арбитрчаар томилогдох этгээд өөрийн хараат бус, бие даасан байдалд эргэлзээ төрүүлэхүйц үндэслэл бүхий нөхцөл байдлын талаар мэдэгдэх үүрэгтэй. Арбитрч дээр дурдсан нөхцөл байдлын талаар талуудад өмнө нь мэдэгдээгүй бол арбитрчаар томилогдсоноос хойш арбитрын ажиллагааны явцад тэрхүү нөхцөл байдлын талаар талуудад даруй мэдэгдэнэ. 14.2.Арбитрчийг гагцхүү хуулиар тогтоосон болон талуудын тохиролцсон мэргэжил, ур чадварын шаардлагад нийцээгүй, эсхүл арбитрчийн хараат бус, бие даасан байдалд эргэлзээ төрүүлэхүйц үндэслэл бүхий нөхцөл байдал байгаа үндэслэлээр татгалзан гаргана.
2	Практикт нийцэж байгаа байдал	Зарим арбитрын байгууллага ёс зүйн дүрэм баталж, энэ асуудлыг нарийн зохицуулахыг зорьсон байв.

Арбитрч нар шүүгч нартай адилаар хэргийг хараат бусаар, хууль болон холбогдон журамд нийцүүлэн шийдэх үүрэг хүлээдэг. Шүүхээс ялгаатай нь арбитрын бүрэлдэхүүнийг талууд сонгох эрхтэй байдаг бөгөөд нэхэмжлэгч аль эсвэл хариуцагч арбитрын хэлэлцээр байгуулах явцдаа хэргээ хянан шийдвэрлүүлэх арбитраа сонгох, эсхүл байнгын арбитрын байгууллагын жагсаалтаас сонгох боломжтой юм. Ийнхүү сонгох боломж нь өөрийн улсын харьяат иргэний арбитрчаар сонгох, эсхүл өөрийн итгэл үнэмшилдээ арбитрчаа сонгох эрхийг эдэлдэг.

Энэхүү сонгох буюу арбитрчаа томилох эрх хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор арбитрчийн хараат бус байдлын талаар асуудал үүсдэг. ЮНСИТРАЛ-ын олон улсын загвар хууль, дүрэм ба Арбитрын тухай Монгол Улсын хуульд ч мөн энэ талаар зохицуулж, талууд арбитрчийг хэрхэн томилох, татгалзах, энэ талаар гомдлыг хэрхэн гаргах талаар заасан байдаг. Зарчмын хувьд арбитрч өөрийг нь томилсон талаар мэдэгдсэн цагаас өөрийн хараат бус байдлын талаар мэдэгдэх үүрэг хүлээдэг. Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх олон улсын арбитрад арбитрчийг татгалзан гаргах хүсэлтийг талууд удаа дараа гаргаж байсан бөгөөд ихэнх тохиолдолд холбогдох хууль болон журамд заасны дагуу арбитрын бүрэлдэхүүн өөрөө шийддэг. Харин арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийг холбогдох тал нь эс зөвшөөрвөл, шүүх эсхүл эрх бүхий этгээдэд гаргаж болдог тогтолцоотой.

МҮХҮТ-ын дэргэдэх Олон улсын арбитрад 2022 оны Арбитрчийн ёс зүйн дүрмийг баталсан байдаг. Энэ дүрэмд арбитрчийн баримтлах зарчим, эрх хэмжээ болон хориглосон үйл ажиллагааг заасан нь арбитрчийн ёс зүйн шаардлагыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой эрх зүйн баримт бичиг байна. Урьд өмнө нь тодорхойгүй байсан, асуудал үүссэн нөхцөлд хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулалтгүй байсан байдлыг шийдэх талаас чухал эх сурвалж болсон юм. Тус дүрмийн заалтыг зөрчсөн нөхцөлд сонирхогч тал нь Арбитрын ажлын албанд гомдол гаргах эрхтэй бөгөөд дүрмийн дагуу байгуулагдсан ёс зүйн хороо гомдлыг хянан шийдвэрлэсэн. Тус хорооны саналыг үндэслэн Арбитрын ажлын алба болон дарга нь тухайн арбитрчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх, үүнд сануулах, эрхийг нь түдгэлзүүлэх, жагсаалтаас хасах эрх хэмжээтэй байна.

В. Арбитрчийн хараат бус байдал, ёс зүйн шаардлага ба олон улсын практик

Америкийн баарын холбоо (АВА) болон Америкийн арбитрчийн холбоо (ААА) 1977 онд хамтран арбитрчийн ёс зүйн журмыг баталсан бөгөөд энэ журамд 2006 дахин нэмэлт өөрчлөлт оруулсан байдаг. Олон улсын баарын холбоо (ИВА) мөн 1987 онд Олон улсын арбитрчийн ёс зүйн журмыг баталсан юм. Аль аль журам нь арбитрчийн хараат бус байдлыг хангах, ашиг сонирхлыг зохицуулах зорилготой аж. Мөн Олон улсын барын холбоо нь 2004 онд арбитрчийн хараат бус байдлын шалгуурын талаар удирдамжийг баталсан нь маргаанд оролцогч талуудад арбитрчийг тухайн хэрэгт холбогдох ашиг сонирхлыг тодорхойлох чухал шалгуур, жагсаалтыг заасан байдаг. Дээр дурдсанаар талууд олон улсын арбитрын ажиллагаанд арбитрчаа сонгох эрхтэй байдаг ба тухайн арбитрч нь талаас хараат бус байх ёстой юм.

Гэхдээ энэ эрх нь олон улсын хэмжээнд зарим хязгаарлалттай байдаг.

- Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх тухай Нью Йоркийн конвенцын 5.1.-д заасны дагуу хэрэв арбитрч томилох үйл ажиллагаа нь арбитрын хэлэлцээрт нь харшилсан, эсхүл холбогдох хууль журамд заасныг зөрчсөн бол арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс татгалзаж болохоор заасан.
- Дотоодын хууль тогтоомжид заасны дагуу мөн арбитрчийг талууд томилж болох бөгөөд ЮНСИТРАЛ-ын Загвар хуулийн 11.2-т заасны дагуу тэгш эрхтэй болон шударга зарчмын дагуу энэ эрхээ эдлэх ёстой гэжээ. Хязгаарлалтыг тухайн улсын хууль болон холбогдох арбитрын дүрэмд заасан байж болно. Эдгээр хязгаарлалт нь арбитрчийн туршлага, мэргэжлийн ур чадвар, хараат бус байдалд тавигдаж буй шаардлага байж болно.
- Арбитрын байгууллагын дүрмийн дагуу талууд мөн арбитрчийг томилох эрхтэй бөгөөд талууд нэг эсхүл гурван арбитрчийг томилоход нийтлэг журмыг баримталдаг.
- Зарим тохиолдолд арбитрчийн хараат бус байдлыг хангах үүднээс зарим арбитрчийг томилоход хязгаарлалт тогтоосон байдаг. Жишээ нь арбитрын хэлэлцээр, хууль, журмаар энэ талаар заасан байж болох бөгөөд хязгаарлах үндэслэл нь тодорхой иргэний харьяалал, ур чадвар, мэргэшлийн шаардлага, сонирхлын зөрчилтэй холбоотой шаардлага байж болно.

Арбитрчийн хараат бус байдалд тавигдах шаардлага нь арбитрчийг томилоход тавигддаг гол шаардлага бөгөөд энэ байдлыг зөрчих нь арбитрын шийдвэрийг хүчингүй болгоход ч нөлөөлөх юм. Энэ талаар ЮНСИТРАЛ-ын Загвар хуулийн 34.2.6, 36.1.6-д заасан байдаг. Үүнтэй холбоотой дараагийн нэг асуудал нь арбитрч нь томилсон талыг төлөөлөх ёстой эсэх асуудал юм. Уламжлалт ойлголтоор бол төлөөлнө гэж үздэг байсан. Харин олон улсын арбитрын үйл ажиллагаанд эсрэгээр хараат бус байхыг шаарддаг. Америкийн баарын холбоо болон олон улсын баарын холбоо ч энэ хандлагыг албан ёсоор шаардаж, Ёс зүйн журамдаа ч заасан байна.

Олон улсын барын холбоо (ИВА)-ны 1987 оны Арбитрчийн Ёс зүйн дүрэм, 2014 оны Олон улсын арбитр дахь сонирхлын зөрчлийн талаар удирдамжид арбитрчийн баримтлах зарчим, хараат бус байдлын дүрмийг заасан байдаг. Удирдамж нь Ёс зүйн дүрмийн зарчимд үндэслэж, тайлбарлаж зохицуулснаас гадна улаан (хориотой), шар (бусад), ногоон (зөвшөөрсөн) өнгөөр сонирхлын зөрчлийг ялгасан байх жишээтэй. Арбитрч нь өөрийн хараат бус байдалд эргэлзээ төрсөн бол энэ талаар арбитрт мэдэгдэхийг шаарддаг юм. Хэрхэн нээлттэй болгох талаар дотоодын хууль эсхүл журамд заасан байж болох бөгөөд ихэнх байнгын арбитрын байгууллагууд мэдэгдэх ажиллагааг журамласан байдаг. Сонирхлын зөрчлийг шалгах шалгуурыг олон улсын арбитрын байгууллагууд нарийвчлан зааж өгдөг. Олон улсын арбитрын үйл ажиллагаанд нэг арбитрчаар хэргээ шийдүүлэх нөхцөлд иргэний харьяаллын хувьд хязгаарлалт тогтоож өгдөг бөгөөд харин хэд хэдэн арбитрч байх нөхцөлд энэ хязгаарлалтыг тогтоох нь ялгаатай байж болно.

Дүгнэлт

1. Арбитрчийн мэргэжлийн ур чадвар нь тухайн арбитрын байгууллагын нэр хүндэд нөлөөлөх төдийгүй, арбитрын ажиллагаанд бүхэлд нь нөлөөлж болно.
2. Ихэнх улс болон арбитрын байгууллагууд арбитрч нарын мэргэжлийн шаардлагын талаар дүрэмдээ заасан байдаг ба энэ нь харилцан адилгүй байна.
3. Монгол Улсад Арбитрын тухай хуульд мэргэжлийн ур чадварт тавьсан шаардлага нь зарим практикт нийцүүлэхэд хүндрэлтэй, сонгон шалгаруулж буй эрх бүхий этгээдийн субъектив хандлагаас хамаарч болзошгүй.
4. Дэлхийн жишгийг харахад Арбитрч томилох талаар арбитрч нарт тавигдах шаардлагын талаар талууд арбитрын хэлэлцээрээр зохицуулж болох бөгөөд үүнийг зөрчих нь арбитрын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болдог байна.
5. Олон улсын хэмжээнд арбитрчийг томилоход түүний ашиг сонирхлын зөрчлийг шалгах удирдамж баталж, баримталж байна.
6. Монгол улс дахь Байнгын арбитрын байгууллагууд арбитрчийн ёс зүйн дүрмийг баталсан ч практикт хэрэгжүүлж байгаа тохиолдол бага, мөн энэ талаар шүүхэд гомдол гаргасан статистик тоо бага байна.

Зөвлөмж

1. Арбитрын мэргэжлийн ур чадварын шаардлагыг тогтоохдоо шалгуур үзүүлэлтийг олон улсын жишигт нийцүүлэн тогтоож, хэт субъектив байдлаар хандахаас хамгаалах
2. Арбитчийн ёс зүйн зөрчлийг хэрхэн шийдэх механизмыг илүү үр дүнтэй болгох
3. Олон улсын жишгийг дагаад ашиг сонирхлын зөрчлийг шалгах шалгуурыг илүү боловсронгуй болгох

2.6 Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхтэй холбоотой асуудал

Дотоод, гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхтэй холбоотой асуудлаар судалгааны баг Шүүхийн Ерөнхий Зөвлөл болон Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газрын тоон мэдээлэл, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ зэргийн хийж гүйцэтгэсэн.

Үнэлэхээр сонгосон заалт

№	Үнэлгээний шалгуур	Сонгосон зүйл заалт
1	Практикт нийцэж байгаа байдал	АтХ-ийн 48, 49-р зүйл

А. Монгол Улсад хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх асуудал

Арбитрын тухай хуулийн 48, 49-р зүйл нь арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэх болон гүйцэтгэхээс татгалзах үндэслэлийг тусгасан. Хуулийн 1-р зүйлд заасан олон улсын стандартад нийцэх зорилтын хүрээнд дээрх хоёр заалт нь ЮНСИТРАЛ-ын Загвар хуультай нийцэлтэйгээс гадна (судалгааны ажлын 2.1-г болон Хавсралтыг үзнэ үү) 1958 оны Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөр биелүүлэх тухай Нью Йоркийн конвенцын агуулгатай нийцэж байдаг тул “зорилгод хүрсэн түвшин” шалгуурыг бүрэн хангасан гэж үзлээ.

Харин “практикт нийцэж байгаа байдал” шалгуурын хүрээнд Шүүхийн Ерөнхий Зөвлөл болон Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газрын тоон мэдээллийг үндэслэн дараах судалгааг гүйцэтгэлээ.

• Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар

Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газраас (ШШГЕГ) 2024 оны 6-р сарын байдлаар гаргасан “дотоод болон гадаадын арбитрын шийдвэртэй гүйцэтгэх баримт бичгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны статистик дата”-г үндэслэн дүн шинжилгээ хийсэн.

Үүнтэй холбоотойгоор, улсын хэмжээнд 2011-2024 онуудад дотоодын болон гадаадын арбитрын шийдвэртэй нийт 151 гүйцэтгэх баримт бичиг үйлдэгдсэнээс 40 орчим баримт бичиг тодорхой бүрэн эсвэл хэсэгчилсэн биелсэн бол 111 баримт бичиг дараах шалтгааны улмаас биелэгдээгүй байна. Үүнд,

- Төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй;
- Төлбөр төлөгчийн оршин суугаа хаян тодорхойгүй, эрэн сурвалжлах ажиллагаа явагдаж байгаа;
- Төлбөр төлөгч хилээр гарсан;
- Хөрөнгөд ажиллагаа хийгдэж байгаа;
- Хэсэгчилсэн төлөлттэй;
- Дараа жилийн төсөвт оруулахаар шийдвэрлэсэн;
- Бусад буюу шүүхээс шинээр ирсэн, ажиллагаа удаашралтай явагдаж байгаа зэрэг шалтгаанууд багтаж байна.

Мөн үлдэгдэл гүйцэтгэх баримт бичгээс 99 нь дотоодын, 22 нь гадаадын арбитрын шийдвэртэй байна. Гүйцэтгэх үнийн дүнгийн хувьд, дотоодын 99 гүйцэтгэх баримт бичиг нь нийт 27,5 тэрбум төгрөгийн дүнтэй бол 22 гадаадын баримт бичиг нь 305,9 тэрбум төгрөгийн дүнтэй байна.

Дээрхээс үзэхэд, шийдвэр гүйцэтгэх баримт бичиг бүхий дотоодын болон гадаадын арбитрын шийдвэрийн биелэлт хангалттай бус байна. Мөн статистик дата-г үндэслэн, гадаадын арбитрын шийдвэр биелэлт дотоодынхоос бага боловч үнийн дүнгээр харьцангуй илүү байгаа нь ажиглагдаж байна.

• Шүүхийн Ерөнхий Зөвлөл

Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс ирүүлсэн арбитрай холбоотой хэрэг маргааныг шүүх шийдвэрлэсэн байдлын тухай албан бичигт үндэслэн дараах дүгнэлтийг хийж болохоор байна.

2018-2023 онуудад Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн дотоодын болон гадаадын арбитрын ажиллагаанд оролцсон мэдээллийг харвал (дэлгэрэнгүй Хавсралт 3-аас харна уу).

- гадаад, дотоодын арбитрын хэлэлцээрийн биелэлтийг баталгаажуулсан болон татгалзсан - нийт 38
- Талууд тохиролцоогүй тохиолдолд арбитрайг томилох - нийт 0
- Арбитрайг татгалан гаргах - нийт 7

- Арбитрын харьяалал - нийт 5
- Нотлох баримт гаргуулахад туслалцаа хүсэх - нийт 12
- Түр арга хэмжээ авах шийдвэрийг гүйцэтгүүлэх - нийт 1
- Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах - нийт 125
- Шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх хүсэлтийг давж заалдсан нэхэмжлэл - нийт 0 байна.

Мөн жилд ойролцоогоор арбитрын маргаантай холбоотой 20-30 хэрэг шүүх дээр шийдэгдсэн байна. Үүнээс үзэхэд, талууд шүүхэд хандах үндэслэл нь арбитрын шийдвэрийн хүчингүй болгуулахтай холбоотой байх бөгөөд арбитрчийг сонгох, харьяалал зэрэг дээр маргах нь харьцангуй цөөн байна.

• Нийслэлийн иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

Энэхүү хэсэгт арбитрын шийдвэртэй холбоотой Нийслэлийн иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн 2017-2023 оны хооронд гарсан шийдвэрт дүн шинжилгээ хийлээ.

Арбитрын процессын үйл ажиллагаатай холбоотой шийдсэн өргөдөл, гомдол:

- арбитрын харьяалал мөн эсэх - 6
- түр арга хэмжээ авах хүсэлт - 0
- арбитрч томилох - 0
- нотлох баримтыг хамгаалах - 1
- бусад хууль зааснаар шүүх оролцох хэрэг - 10
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой арбитрын маргаан - 8

Арбитрын шийдвэрийг давж заалдсан хэрэг, тэдгээрийн шийдвэр:

- Хүлээн авахаас татгалзах - 1 (“төлбөрийг хэрхэн төлөх талаар нарийвчлан заагаагүй, агуулгын хүрээнд тодорхойгүй байхад шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг үүсгэсэн тогтоол гаргасан нь хууль зөрчсөн” хэмээн гомдол гаргасан боловч арбитрын шүүхийн шийдвэрийг буцаах үндэслэл тогтоогдоогүй тул энэ талаар гаргасан давж заалдах гомдлыг хангах боломжгүй)
- Биелүүлэхээс татгалзах - 1 (арбитрын шийдвэрийг давж заалдсан шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж хэрэгсэхгүй болгосон)

Үүнээс үзэхэд, шүүхэд арбитрын ажиллагаатай холбоотой маргаан бусад салбарын маргаантай харьцуулбал цөөн байдаг ба Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийг үндэслэн арбитрын харьяаллын маргаан мөн эсэх талаар шийдвэрлэдэг байна. Арбитрын харьяалал, арбитрын хэлэлцээртэй, арбитрын хүчин төгөлдөр шийдвэр байгаа гэж үзсэн тохиолдолд шүүх хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж байна.

Дүгнэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх баримт бичиг бүхий дотоодын болон гадаадын арбитрын шийдвэрийн биелэлт хангалттай бус байна. Мөн статистик дата-г үндэслэн, гадаадын арбитрын шийдвэр биелэлт дотоодынхоос бага боловч үнийн дүнгээр харьцангуй илүү байгаа нь ажиглагдаж байна. Мөн шүүхэд арбитрын ажиллагаатай холбоотой маргаан бусад салбарын маргаантай харьцуулбал цөөн байдаг ба Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийг үндэслэн арбитрын харьяаллын маргаан мөн эсэх талаар шийдвэрлэдэг байна. Арбитрын харьяалал, арбитрын хэлэлцээртэй, арбитрын хүчин төгөлдөр шийдвэр байгаа гэж үзсэн тохиолдолд шүүх хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж байна.

Дээрх судалгааны тоо баримт нь Арбитрын тухай хуулийн 48, 49-р зүйлийн практик хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэх бөгөөд харьяаллын заалтыг тодорхой болгох, арбитрын шийдвэрийг гүйцэтгэх процессыг хөнгөвчлөх зэрэгт чиглэсэн үйл ажиллагаа нь практикт хэрэгжих байдлыг нэмэгдүүлэх боломжтой.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Монгол Улсын Арбитрын тухай хууль нь 2017 онд батлагдсанаас хойш 5 жил өнгөрчээ. Хууль тогтоомжийн хуулийн дагуу 5 жил тутамд хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагатай ба энэ хүрээнд Арбитрын тухай хуульд үнэлгээ хийлээ. Тус хэрэгжилтийн үр дагаврын судалгааны үндсэн дээр хуулийн бүлгээр ангилан “зорилгод хүрсэн түвшин” болон “практикт нийцэж байгаа байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэлгээг хийж гүйцэтгэсэн ба дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд,

3.1 Арбитрын тухай хууль олон улсын загвар дүрэмд нийцсэн эсэх

Арбитрын тухай хуулийн 1-р зүйлд, хуулийн зорилтыг тусгасан бөгөөд *“арбитрын ажиллагааны зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэн зохицуулахад оршино”* хэмээн заажээ. Энэ хүрээнд, АтХ-ийг олон улсын стандартад нийцсэн эсэхийг НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын (ЮНСИТРАЛ) Загвар хуулийг зүйл, заалтуудтай нийцсэн эсэхийг үнэлсэн.

Ерөнхий байдлаар Арбитрын тухай хууль нь НҮБ-ын Загвар хуультай нийцэлтэй байгаа нь “зорилгод хүрсэн түвшин” шалгуурын зорилтод хүрсэн гэж дүгнэлээ. Гэвч зарим зохицуулалтыг илүү тодорхой болгох шаардлагатай байна.

Энэ нь АтХ-ийн 1-р зүйлд тусгагдсан “олон улсын стандартад нийцүүлэн зохицуулах” зорилтын хангаж байна. Харин, “практикт нийцэж байгаа байдал” шалгуурыг бүрэн хангах хүрээнд дээр дурдсан тодруулыг оруулах шаардлагатай.

Үүнд:

- Арбитрын тухай хууль нь дотоодын болон олон улсын арбитрын маргаанд хэрэглэгдэхээр зохицуулагдсаныг харгалзан процессын ялгааг тодорхой болгох. Ингэхдээ, төрөлжсөн арбитрын маргаануудын зохицуулалтыг онцлогийг тусгах.
- Арбитрын тухай хуулийн 13.1.3-т заасан *“өөр ажил, албан тушаал хавсран эрхлэхийг хориглосон хуулийн шаардлагыг зөрчөөгүй байх”* шалгуурыг холбогдох хуулийн заалтуудаар дэлгэрүүлэх.
- Арбитрын тухай хуулийн 14.2-т заасан арбитрчийг татгалзан гаргах *“хуулиар тогтоосон шаардлагад нийцээгүй”* байх шаардлагыг холбогдох хуулийн заалтуудаар тодорхойлох.
- Арбитрын тухай хуулийн 10.1-д заасан **арбитрын харьяалалыг** тодорхой болгох үүднээс нарийвчлан томъёолох шаардлагатай. Тухайлбал, талуудын аль нэг нь тайлбар гаргаснаар арбитрын журмаар маргааныг шийдвэрлүүлэх хүсэлт хүлээж авахгүй мэт томъёолсон байгаа нь тодорхой бус байдал үүсгэх боломжтой. Мөн, талуудын хүсэл зоригийг илрэл, чөлөөт байдлын зарчим дээр үндэслэсэн арбитрын хэлэлцээрийн хүчин төгөлдөр эсэхийг заавал маргааны аль нэг тал хүсэлт гаргаснаар шийдвэрлэх нь зохимжгүй байж болох юм.
- Арбитрын тухай хуулийн зохицуулалт арилжааны маргаанаар хязгаарлагдаагүйг онцлон бусад тусгайлсан арбитрад хамаарах зохицуулалтыг тусгах.
- Арбитрын тухай хуулийн 13.4, 13.5 болон 16.1-д зохицуулагдсан “эрх бүхий этгээд”-д хэн багтах, арбитрын бүрэлдэхүүн багтах бол тэдгээрийн эрх хэмжээ зэргийг хуульчлах.
- Арбитрын тухай хуульд арбитрын цахим процессын хүчин төгөлдөр байдлыг тусгах шаардлагатай ба дотоодын арбитрын байгууллагууд өөрсдийн журмаараа зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.
- Арбитрын тухай хуульд арбитрын ажиллагааны журмыг “дүрэм” хэмээн нэрлэсэн байгаа нь үл ойлголцол үүсгэх боломжтой бөгөөд олон улсын практикт нийцүүлэн “арбитрын ажиллагааны журам” гэвэл зохимжтой.

3.2 Байнгын арбитр болон байнгын бус арбитраар хэрэг хянан шийдвэрлүүлсэн байдал

Олон улсын арилжааны болон бусад арбитрын төрлийг байнгын болон байнгын бус хэмээн ангилах нь стандарт зохицуулалт бөгөөд өөрсдийн гэсэн онцлогтой байна. Харин Монгол Улсын дотоодын зохицуулалтад байнгын арбитрыг тодорхой зохицуулсан боловч байнгын бус арбитрын төдийлөн онцлон зохицуулж чадаагүй байна. Үүний улмаас, маргааны талууд байнгын бус арбитраар маргаан шийдвэрлүүлэх нь бага байх боломжтой. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын хувьд, АтХ-ийн 7-р зүйлд тусгагдсан арбитрын төрлүүдийн нэг болох байнгын бус арбитрын ойлголт, зохицуулалтын онцлог зэрэг нь хангалтгүй байгаа бөгөөд үүний улмаас практикт хэрэгжих боломж нь хязгаарлагдмал байх юм.

Иймд, Арбитрын тухай хуульд байнгын бус арбитраар маргаан шийдвэрлүүлэхэд анхаарах зохицуулалтуудыг тусгаж өгөх нь зүйтэй юм. Үүнд тухайлбал, гэрээний чөлөөт байдлын зарчмыг үндэслэн үүсгэн байгуулагдах түр арбитрын процессын журмын хуульд нийцсэн байдал, мэргэшсэн арбитрчийн тодорхойлолт болон шийдвэр биелэлтийг хангах зохицуулалтууд багтах боломжтой.

3.3 Арбитрын үйл ажиллагааны зохицуулалтын, хэрэгжилт, дүрэм олон улсын жишигт нийцсэн байдалд:

Монгол Улсад Арбитрын тухай хуульд заасны дагуу байнгын арбитрын байгууллагууд байгуулагдаж, арбитрын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Байнгын арбитрын байгууллагууд хуульд заасны дагуу дүрмээ баталж, арбитрын үйл ажиллагаатай холбоотой журмаа баталсан байдаг. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Олон улсын арбитр, Улаанбаатар хотын Үндэсний ба Олон улсын арбитр, Монголын ба олон улсын спортын арбитр, Барилгын арбитр байгуулагдан ажиллаж байна.

Арбитрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-дэх хэсгийн дагуу байнгын арбитрын байгууллагууд байгуулагдаж, иргэд хуулийн этгээд маргаанаа арбитраар хянан шийдвэрлүүлж байгаа байдлыг үндэслэхэд тодорхой хэмжээнд зорилгодоо хүрч, хүлээн зөвшөөрөгдсөн байна гэж үнэлэгдсэн юм. Тодорхой хэмжээнд зорилгодоо хүрсэн гэж үнэлсэн нь хэд хэдэн үндэслэлтэй юм.

1. Байнгын бус арбитраар хэргээ хянуулж байгаа байдал цөөхөн, арбитрын байгууллагаас тусламж байгаа мэдээлэл бүртгэгдээгүй байна
2. Байнгын үйл ажиллагаа явуулж буй арбитрын байгууллагууд олон улсын ба дотоодын маргааныг давхар хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй. Байгууллагын хүрээнд баталсан дүрэм ч мөн маргааны төрлийг нь онцолж, зааглахгүй зохицуулсан.
3. Хэдий иргэд, хуулийн этгээд маргаанаа арбитраар хянан шийдвэрлүүлэхээр хандаж байгаа ч энэ тоо нь шүүхээр хянан шийдвэрлүүлж байгаа тооноос бага бөгөөд тусгай төрөлжсөн арбитраудад хандах тоо ч бага байна.
4. Байнгын арбитрын байгууллагууд дүрмээ өөрийн онцлогт тохируулан боловсруулж, зарим нь Арбитрын тухай хуультай зөрчилдсөн байна.

Иймд Арбитрын тухай хуулийн зорилгод бүрэн нийцүүлэх, практиктай нь уялдуулах, нийтээр хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор дараах зүйлийг анхаарах нь зүйтэй.

Зөвлөмж:

1. Арбитрын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах зорилгор Арбитрын тухай хуульд Монгол улс дахь байнгын арбитрауд дүрэм, журмаа нийцүүлэх
2. Олон улсын ба дотоодын маргааны хувьд ялгаатай зохицуулалт тогтоох. Олон улсын маргаан шийдвэрлэж байгаа арбитрад дүрэм журмаа олон улсын жишигт нийцүүлэх
3. Арбитрын холбогдох дүрмээр үйл ажиллагаагаа зохицуулахдаа арбитрчийг томилох, талууд тэгш эрх, хэрэглэх эх сурвалж, арбитрын ажиллагаа, гаргах бүхий л шийдвэр, эцсийн шийдвэрийн талаар зохицуулалтыг АтХ-д нийцүүлэх, хуультай зөрчилдөж буй байдлыг арилгах.
4. Байнгын бус арбитрын үйл ажиллагааг дэмжиж, байнгын арбитр дээр энэ төрлийг үйл ажиллагааг дэмжсэн зохицуулалтыг бий болгох

3.4 Арбитрын үйл ажиллагаа дахь шүүхийн оролцоог хязгаарлаж, зохицуулах

Монгол Улсын Арбитрын тухай хууль болон ЮНСИТРАЛ-ын Арбитрын Загвар хууль шүүх арбитрын ажиллагаанд хэрхэн оролцох, ямар нөхцөлд оролцож болох талаар зохицуулалт нь нийтлэг байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу зорилгодоо хүрсэн болон практикт нийцсэн байдлыг нь үнэлэхэд шүүхийн талаар зохицуулалт нь олон улсын стандартад нийцсэн байна.

1. Харин практикт нийцсэн байдлыг нь авч үзэхэд ЮНСИТРАЛ-ын загвар хуульд арбитрын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шийдүүлэхээр хуульд заасан эрх бүхий этгээд, тухайлбал байнгын арбитр, даргалагч арбитр болон шүүхээр хандах боломжтой ч Арбитрын тухай хуульд эрх бүхий этгээд нь хэн гэдгийг нь нарийн зааж өгөөгүй тул практикт ихэвчлэн шүүхэд хандаж байна.
2. Байнгын арбитрын байгууллагууд дүрэмдээ дээр дурдсан эрх бүхий этгээдийн эрхийг өөрийн арбитраа шилжүүлсэн байдал тун бага байна.
3. Хэдий Арбитрын тухай хуульд Арбитрын байгууллагуудад арбитрын үйл ажиллагаанд туслах

эрх хэмжээг олгосон ч бусад хуулийн зохицуулалт, жишээ нь Шүүхийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.2, 160¹- р зүйлд заасан болон Арбитрын тухай хуулийн хуулийн холбогдох зохицуулалтад эрх бүхий этгээдийг заагаагүйн улмаас заавал шүүхээс тусламж авах хэрэгтэй болоод байна.

4. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрүүдэд анализ хийхэд арбитрын шийдвэрийг харьяаллын бус маргаан шийдсэн, арбитрын бүрэлдэхүүн томилоход талуудын тэгш эрхийг хангаагүй, талуудын тэгш оролцоог хангаагүй, нэхэмжлэлийн шаардлагад заасан маргааныг шийдээгүй гээд ихэвчлэн процессын алдааны улмаас арбитрын шийдвэрийг хүчин төгөлдөр болсон байна.

Зөвлөмж

1. Эрх бүхий этгээдийг Арбитрын тухай хуульдаа тодорхойлж өгөх
2. Арбитрын тухай хууль болон бусад хуульд арбитрын байгууллага арбитрын ажиллагаатай холбоотой эрх хэмжээг шүүхээр дамжуулахгүй байх боломжийг олгосон зохицуулалтыг нэвтрүүлэх
3. Байнгын арбитрын байгууллагууд дүрмээ олон улсын жишигт нийцүүлэн арбитраар болон арбитрын бүрэлдэхүүнээр шийдвэрлэж болох эрх хэмжээг зааж, шүүхийн оролцоог багасгах
4. Арбитрын ажиллагаа, олон улсын стандартын талаар арбитрч болон шүүгч нарыг сургах

3.5 Арбитрын мэргэжлийн ур чадвар, ёс зүй, сонирхлын зөрчлөөс хамгаалах зохицуулалт

Арбитраар маргаанаа хянан шийдүүлэх практик Монгол улсад харьцангуй шинэ байна. Үүнийг дагаад арбитрын үйл ажиллагааг олон улсын стандартад, түүний зорилгод нийцүүлэн хэрэгжүүлж байгаа байдал дутагдалтай байна. Арбитрын байгууллагууд болон арбитрчид өөрсдөө энэ талын мэдлэг сайтай бол уг соёлыг түгээн дэлгэрүүлж, арбитрын үйл ажиллагааг үр дүнтэй болгож чадах юм. Монгол Улс дахь байнгын арбитрын дүрэм, хэрэг хянан шийдвэрлэх дүрэм, шүүхээр шийдэж байгаа гомдлын байдлыг авч үзэхэд арбитрчийн олон улсын арбитрын ажиллагааны талаар мэдлэг хязгаарлагдмал, заримдаа дутмаг байна гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Энэхүү судалгааг хийхэд ашигласан үнэлгээний шалгуурын дагуу авч үзэхэд зорилгодоо хүрсэн үү гэхээр хэсэгчлэн хүрсэн, практикт нийцэж байна уу гэсэн асуултад бүрэн нийцэж чадахгүй байна гэж үнэлэгдсэн юм.

Зөвлөмж

1. Арбитрын мэргэжлийн ур чадварт тавигдаж байгаа шаардлагыг өөрчилж, практикт нийцсэн, арбитрын үйл ажиллагаанд шаардагдах мэдлэг ур чадварыг шаардах
2. Арбитрчийг томилохдоо түүний тухайн хэрэгт сонирхлын зөрчлийг тогтоох шалгуурыг зааж, олон улсын жишигт нийцүүлэх
3. Ёс зүйн зөрчлийг шийдэг зохицуулалтыг нийтээр хэвшүүлэх
4. Арбитрч нарыг тогтмол сургалтад хамруулах

3.6. Арбитрын шийдвэр биелүүлэх талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх баримт бичиг бүхий дотоодын болон гадаадын арбитрын шийдвэрийн биелэлт хангалттай бус байна. Мөн статистик дата-г үндэслэн, гадаадын арбитрын шийдвэр биелэлт дотоодынхоос бага боловч үнийн дүнгээр харьцангуй илүү байгаа нь ажиглагдаж байна. Мөн шүүхэд арбитрын ажиллагаатай холбоотой маргаан бусад салбарын маргаантай харьцуулбал цөөн байдаг ба Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийг үндэслэн арбитрын харьяаллын маргаан мөн эсэх талаар шийдвэрлэдэг байна. Арбитрын харьяалал, арбитрын хэлэлцээртэй, арбитрын хүчин төгөлдөр шийдвэр байгаа гэж үзсэн тохиолдолд шүүх хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж байна.

Дээрх судалгааны тоо баримт нь Арбитрын тухай хуулийн 48, 49-р зүйлийн практик хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэх бөгөөд харьяаллын заалтыг тодорхой болгох, арбитрын шийдвэрийг гүйцэтгэх процессыг хөнгөвчлөх зэрэгт чиглэсэн үйл ажиллагаа нь практикт хэрэгжих байдлыг нэмэгдүүлэх боломжтой.

Нэгдсэн санал, зөвлөмж

Энэхүү хэсэгт Арбитрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд анхаарах зүйл заалт, хуулийн үзэл санааг хамгаалах санал зөвлөмжийг орууллаа. Нэгдсэн байдлаар дүгнэхэд, Арбитрын тухай хууль нь олон улсын стандартад нийцүүлэн боловсруулагдсан тул шинэчлэн найруулах шаардлагагүй бөгөөд харин зарим нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой байна.

1. Арбитрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд дараах зөвлөмжийг харгалзах, үүнд:
 - Спортын, хөдөлмөрийн зэрэг төрөлжсөн тусгай арбитрын үйл ажиллагааг ялгаатай зохицуулах. Ингэхдээ, Арбитрын тухай хуульд тусгайлсан зохицуулалт оруулах, эсвэл өөр тусгайлсан хуулиар (спортын тухай зэрэг) зохицуулдаг байх; Одоогийн хэрэгжиж буй Арбитрын тухай хуульд тусгайлсан арбитрын зохицуулалт багтаагүй байна.
 - Олон улсын ба дотоодын маргаанд ялгаатай хэрэг хянан шийдвэрлэх журам хэрэглэх талаар хуульд “арбитрын төрөл” эсвэл “арбитрын харьяаллын маргаан” хэсэгт тусгах тусгах;
 - Арбитрын үйл ажиллагаанд хамааралгүй, тухайлбал дампуурал зэрэг, асуудлыг хуулиас хасах;
 - Арбитрын тухай хуулийн 13.1.3-т заасан “*өөр ажил, албан тушаал хавсран эрхлэхийг хориглосон хуулийн шаардлагыг зөрчөөгүй байх*” шалгуурыг холбогдох хуулийн заалтуудаар дэлгэрүүлэх;
 - Арбитрын тухай хуулийн 14.2-т заасан арбитрчийг татгалзан гаргах “*хуулиар тогтоосон шаардлагад нийцээгүй*” байх шаардлагыг холбогдох хуулийн заалтуудаар тодорхойлох;
 - Арбитрын тухай хуулийн 7.2, 13.4, 13.5 болон 16.1-д заасан “эрх бүхий этгээд”-д хэн багтах, арбитрын бүрэлдэхүүн багтах бол тэдгээрийн эрх хэмжээ зэргийг хуульчлах;
 - Арбитрын хэргийн харьяаллыг олон улсын жишигт нь нийцүүлэн арбитрын хэлэлцээр, шүүхийн харьяалал зэргээр хязгаарлахгүйгээр салбар эрх зүй буюу “хувийн эрх зүйн” харилцаа байхыг тодотгох; Энэ нөхцөлд бусад тусгай арбитрын харьяаллыг өөр хуулиар зохицуулах мөн эд хөрөнгийн бус маргааныг хянан шийдвэрлэхгүй байх талаар тусгах;
 - Арбитрын тухай хуульд арбитрын цахим процессын хүчин төгөлдөр байдлыг тусгах шаардлагатай ба дотоодын арбитрын байгууллагууд өөрсдийн журмаараа зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;
 - Зарим улсад улс хариуцагчаар орж байгаа маргааныг Арбитраар хянан шийдвэрлэхгүй байх талаар заасан байдаг тул энэ асуудлыг мөн хуулиар зохицуулан зааж өгөх (Казахстан улсын Арбитрын тухай хууль, 2016 он);
 - Арбитрын ажиллагааны явцад тодорхой шийдвэрийг эрх бүхий этгээд болон шүүх гаргахаар зохицуулсан тул “эрх бүхий этгээд”-ийг тодорхойлох;
 - Арбитрч нарт тавигддаг шаардлагыг насны хязгаарлалт, мэргэжил, салбартаа мэргэшсэн байдлын шалгуур зэргээр тогтоож олон улсын жишигт нийцүүлэх;
 - Арбитрын бүрэлдэхүүний гарах шийдвэрийг зааглаж тодорхойлох, тухайлбал арбитрын ажиллагааны явцад гарах шийдвэр, эцсийн шийдвэрийн томьёоллыг тодорхойлох;
 - Арбитрын танхим, холбоо байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх; (Байнгын арбитрын байгууллагуудын үйл ажиллагааг хуульд нийцүүлэх, сургалт хийх, үйл ажиллагаанд нь мониторинг хийх);
2. Арбитрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотойгоор гадаад орнуудын арбитрын тухай хуульд харьцуулсан судалгаа хийн, хэрхэн нэмэлт өөрчлөлт оруулах талаар дүгнэлт гаргах;
3. Арбитрын хэргийн харьяаллын талаар мөн бусад орны зохицуулалтыг харьцуулан судлах, ялангуяа онцгой маргаан шийдвэрлэдэг спортын, хөдөлмөрийн арбитр, улсын онцгой харьяалалд байдаг маргааныг хэрхэн талаар тусдаа судалгаа хийх;
4. Арбитрын хуулийг хэрэгжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулалттайгаар гүйцэтгэх. Тухайлбал, арбитрч, шүүгч нарыг мэргэшүүлэх, арбитрчийн мэргэжлийн ур чадварт тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, субъектив байдлаар жагсаалтад оруулах байдлыг багасгах зэргийг дурдаж болно.
5. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам, дүрмийг олон улсын маргаан ба дотоодын маргаанаар зааглан зохицуулах, олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх;
6. Хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн актыг “журам” гэж нэрлэн олон улсын стандартад нийцүүлэх. Үүнтэй холбоотойгоор, Арбитрын тухай хуулийн 7 дугаар зүйлийг зөв тайлбарлаж хэрэглэх;
7. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй байнгын арбитуудын дүрмийг Арбитрын тухай хуульд нийцүүлэх;

8. Онцгой, холимог эрх зүйн харилцааны маргааны шийдвэрлэдэг, олон улсын дүрмээр үйл ажиллагаагаа явуулдаг (Олон улсын спортын холбоо, байгууллагуудын хувьд) тусгай арбитрын зохицуулалтыг бусад улсын жишээ дээр харьцуулсан судалгаа хийх;
9. 8-р зүйлд дурдсан арбитрын холбогдох дүрмээр үйл ажиллагаагаа зохицуулахдаа арбитрчийг томилох, талууд тэгш эрх, хэрэглэх эх сурвалж, арбитрын ажиллагаа, гаргах бүхий л шийдвэр, эцсийн шийдвэрийн талаар зохицуулалтыг АтХ-д нийцүүлэх;
10. Арбитрын ажиллагааг арбитрын бүрэлдэхүүн өөрөө шууд хэрэгжүүлэх талаар, тухайлбал нотлох баримт цуглуулах, түр арга хэмжээ авах талаар зохицуулалтыг хуульд тусгаж өгөх;
11. Арбитрчийн ёс зүйн зөрчлийг хэрхэн шийдэх механизмыг хуульчлах, эсхүл арбитрын байгууллагын дүрмээр зохицуулах эрхийг хуулиар олгох;
12. Олон улсын жишгийг дагаад арбитрын ажиллагааны оролцогчдын ашиг сонирхлын зөрчлийг шалгах шалгуурыг илүү боловсронгуй болгох.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. UNCITRAL Model Law on International Commercial Arbitration, 1985
2. UNCITRAL Arbitration rules, 1976
3. Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц, 1958
4. Монгол Улсын Арбитрын тухай хууль, 2017
5. МОУА-ын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүрэм, 2017
6. Улаанбаатар хотын худалдааны танхимын дэргэдэх арбитрын маргаан хэрэг хянан шийдвэрлэх журам, 2022
7. Монголын барилгачдын холбооны дэргэдэх Байнгын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүрэм, 2007
8. Монголын Олон улсын ба үндэсний спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүрэм, 2017
9. Хөдөлмөрийн арбитрын дүрэм батлах тухай, МУ-ын Их хурлын 2001 оны 55 дугаар тогтоол,
10. Gary B. Born, International Arbitration: Law and Practice, third edition, Kluwer Law International B.V.
11. Lawrence W. Newman, Richard D. Hill Editors, The Leading arbitrator's guide to International arbitration, Juris Publishing, Inc, 2004
12. Монгол Улс дахь арбитрын байгууллага, түүхэн товчоон, 1930-2020
13. Монгол Улс дахь арбитрын эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, ХЗҮХ-ийн хэвлэх газар, 2020 он
14. Казахстан улсын Арбитрын тухай хууль, 2016 он
15. Арбитрын тухай гадаад орны хууль тогтоомж, <https://www.international-arbitration-attorney.com/ru/arbitration-law-of-world/>
16. БНХАУ-ын арбитрын тухай хууль

ХАВСРАЛТ**Хавсралт 1. Хүснэгт 1. UNCITRAL Загвар хууль ба Монгол Улсын Арбитрын тухай хуулийн харьцуулалт**

UNCITRAL Загвар хууль	Монгол Улсын Арбитрын тухай хууль
Байхгүй	1 дүгээр зүйлийн 1.1
1 дүгээр зүйл (1) өөр	2 дугаар зүйлийн 2.1
1 дүгээр зүйл (2)	2 дугаар зүйлийн 2.2
2 дугаар зүйл (а)	3 дугаар зүйлийн 3.1
1 дүгээр зүйл (3)	3 дугаар зүйлийн 3.2
1 дүгээр зүйл (4)	3 дугаар зүйлийн 3.3
1 дүгээр зүйл (5)	Байхгүй
Байхгүй	3 дугаар зүйлийн 3.4
3 дугаар зүйл (1) (b)	4 дүгээр зүйлийн 4.1
3 дугаар зүйл (1) (a)	4 дүгээр зүйлийн 4.2
3 дугаар зүйл (2)	4 дүгээр зүйлийн 4.3
4 дүгээр зүйл	5 дугаар зүйлийн 5.1
5 дугаар зүйл	6 дугаар зүйлийн 6.1
6 дугаар зүйл	6 дугаар зүйлийн 6.2
	6 дугаар зүйлийн 6.1
Байхгүй	7 дугаар зүйл
7 дугаар зүйл (1)	8 дугаар зүйлийн 8.1
	8 дугаар зүйлийн 8.2
7 дугаар зүйл (2)	8 дугаар зүйлийн 8.3
7 дугаар зүйл (3)	8 дугаар зүйлийн 8.4
	8 дугаар зүйлийн 8.5
7 дугаар зүйл (4)	8 дугаар зүйлийн 8.6
	8 дугаар зүйлийн 8.7
7 дугаар зүйл (5)	8 дугаар зүйлийн 8.8
7 дугаар зүйл (6)	8 дугаар зүйлийн 8.9
Байхгүй	8 дугаар зүйлийн 8.10
Байхгүй	8 дугаар зүйлийн 8.11
Байхгүй	9 дүгээр зүйлийн 9.1
8 дугаар зүйл (1)	10 дугаар зүйлийн 10.1
8 дугаар зүйл (2)	10 дугаар зүйлийн 10.2
9 дүгээр зүйл	11 дүгээр зүйлийн 11.1
2 дугаар зүйл (b)	12 дугаар зүйлийн 12.1
10 дугаар зүйл (1)	12 дугаар зүйлийн 12.2
10 дугаар зүйл (2)	12 дугаар зүйлийн 12.3
Байхгүй	13 дугаар зүйлийн 13.1
11 дүгээр зүйл (1)	13 дугаар зүйлийн 13.2
11 дүгээр зүйл (2)	13 дугаар зүйлийн 13.3
11 дүгээр зүйл (3)	13 дугаар зүйлийн 13.4
11 дүгээр зүйл (4)	13 дугаар зүйлийн 13.5
	13 дугаар зүйлийн 13.6
11 дүгээр зүйл (5)	13 дугаар зүйлийн 13.7
	13 дугаар зүйлийн 13.8

12 дугаар зүйл (1)	14 дүгээр зүйлийн 14.1
12 дугаар зүйл (2) өөр	14 дүгээр зүйлийн 14.2
	14 дүгээр зүйлийн 14.3
13 дугаар зүйл (1)	15 дугаар зүйлийн 15.1
13 дугаар зүйл (2) өөр	15 дугаар зүйлийн 15.2
13 дугаар зүйл (3) өөр	15 дугаар зүйлийн 15.3
14 дүгээр зүйл (1)	16 дугаар зүйлийн 16.1
14 дүгээр зүйл (2)	16 дугаар зүйлийн 16.2
15 дугаар зүйл	17 дугаар зүйлийн 17.1
16 дугаар зүйл (1)	18 дугаар зүйлийн 18.1
	18 дугаар зүйлийн 18.2
16 дугаар зүйл (2)	18 дугаар зүйлийн 18.3
	18 дугаар зүйлийн 18.4
	18 дугаар зүйлийн 18.5
16 дугаар зүйл (3)	18 дугаар зүйлийн 18.6
	18 дугаар зүйлийн 18.7
	18 дугаар зүйлийн 18.8
17 дугаар зүйл (1)	19 дүгээр зүйлийн 19.1
17 дугаар зүйл (2)	19 дүгээр зүйлийн 19.2
17 А дугаар зүйл (1)	20 дугаар зүйлийн 20.1
17 А дугаар зүйл (1) (b)	20 дугаар зүйлийн 20.2
17 А дугаар зүйл (2)	20 дугаар зүйлийн 20.3
17 В дугаар зүйл (1)	21 дүгээр зүйлийн 21.1
17 В дугаар зүйл (2)	21 дүгээр зүйлийн 21.2
17 В дугаар зүйл (3)	21 дүгээр зүйлийн 21.3
17 С дугаар зүйл (1)	22 дугаар зүйлийн 22.1
17 С дугаар зүйл (2)	22 дугаар зүйлийн 22.2
17 С дугаар зүйл (3)	22 дугаар зүйлийн 22.3
17 С дугаар зүйл (4)	22 дугаар зүйлийн 22.4
17 С дугаар зүйл (5)	22 дугаар зүйлийн 22.5
	22 дугаар зүйлийн 22.6
17 D дугаар зүйл	23 дугаар зүйлийн 23.1
17 E дугаар зүйл (1)	24 дүгээр зүйлийн 24.1
17 E дугаар зүйл (2)	24 дүгээр зүйлийн 24.2
17 F дугаар зүйл (1)	25 дугаар зүйлийн 25.1
17 F дугаар зүйл (2)	25 дугаар зүйлийн 25.2
17 G дугаар зүйл	26 дугаар зүйлийн 26.1
	26 дугаар зүйлийн 26.2
17 H дугаар зүйл (1)	27 дугаар зүйлийн 27.1
	27 дугаар зүйлийн 27.2
17 H дугаар зүйл (2)	27 дугаар зүйлийн 27.3
17 H дугаар зүйл (3)	27 дугаар зүйлийн 27.4
17 I дугаар зүйл (1)	28 дугаар зүйлийн 28.1
17 I дугаар зүйл (2)	28 дугаар зүйлийн 28.2
17 J дугаар зүйл	29 дүгээр зүйлийн 29.1
18 дугаар зүйл	30 дугаар зүйлийн 30.1
19 дүгээр зүйл (1)	31 дүгээр зүйлийн 31.1
19 дүгээр зүйл (2)	31 дүгээр зүйлийн 31.2

20 дугаар зүйл (1)	32 дугаар зүйлийн 32.1
20 дугаар зүйл (2)	32 дугаар зүйлийн 32.2
21 дүгээр зүйл	33 дугаар зүйлийн 33.1
22 дугаар зүйл (1)	34 дүгээр зүйлийн 34.1
	34 дүгээр зүйлийн 34.2
	34 дүгээр зүйлийн 34.3
22 дугаар зүйл (2)	34 дүгээр зүйлийн 34.4
23 дугаар зүйл (1)	35 дугаар зүйлийн 35.1
	35 дугаар зүйлийн 35.2
23 дугаар зүйл (2)	35 дугаар зүйлийн 35.3
24 дүгээр зүйл (1)	36 дугаар зүйлийн 36.1
	36 дугаар зүйлийн 36.2
24 дүгээр зүйл (2)	36 дугаар зүйлийн 36.3
24 дүгээр зүйл (3)	36 дугаар зүйлийн 36.4
	36 дугаар зүйлийн 36.5
25 дугаар зүйл	37 дугаар зүйлийн 37.1
26 дугаар зүйл (1)	38 дугаар зүйлийн 38.1
26 дугаар зүйл (2)	38 дугаар зүйлийн 38.2
27 дугаар зүйл	39 дүгээр зүйлийн 39.1
28 дугаар зүйл (1) өөр	40 дүгээр зүйлийн 40.1
	40 дүгээр зүйлийн 40.2
28 дугаар зүйл (2)	40 дүгээр зүйлийн 40.3
28 дугаар зүйл (3)	40 дүгээр зүйлийн 40.4
28 дугаар зүйл (4)	40 дүгээр зүйлийн 40.5
Байхгүй	41 дүгээр зүйл
29 дүгээр зүйл	42 дугаар зүйлийн 42.1
	42 дугаар зүйлийн 42.2
30 дугаар зүйл (1)	43 дугаар зүйлийн 43.1
30 дугаар зүйл (2)	43 дугаар зүйлийн 43.2
31 дүгээр зүйл (1) өөр	44 дүгээр зүйлийн 44.1
31 дүгээр зүйл (2)	44 дүгээр зүйлийн 44.2
31 дүгээр зүйл (3) өөр	44 дүгээр зүйлийн 44.3
31 дүгээр зүйл (4)	44 дүгээр зүйлийн 44.4
32 дугаар зүйл (1)	45 дугаар зүйлийн 45.1
32 дугаар зүйл (2)	45 дугаар зүйлийн 45.2
32 дугаар зүйл (3)	45 дугаар зүйлийн 45.3
33 дугаар зүйл (1) (a)	46 дугаар зүйлийн 46.1
33 дугаар зүйл (1) (b)	46 дугаар зүйлийн 46.2
	46 дугаар зүйлийн 46.3
33 дугаар зүйл (2)	46 дугаар зүйлийн 46.4
33 дугаар зүйл (3)	46 дугаар зүйлийн 46.5
33 дугаар зүйл (4)	46 дугаар зүйлийн 46.6
33 дугаар зүйл (5)	46 дугаар зүйлийн 46.7
34 дүгээр зүйл (1)	47 дугаар зүйлийн 47.1
34 дүгээр зүйл (2)	47 дугаар зүйлийн 47.2
34 дүгээр зүйл (3) өөр	47 дугаар зүйлийн 47.3
34 дүгээр зүйл (4)	47 дугаар зүйлийн 47.4
Байхгүй	47 дугаар зүйлийн 47.5

35 дугаар зүйл (1) өөр	48 дугаар зүйлийн 48.1
35 дугаар зүйл (2)	48 дугаар зүйлийн 48.2
36 дугаар зүйл (1)	49 дүгээр зүйлийн 49.1
36 дугаар зүйл (2)	49 дүгээр зүйлийн 49.2
Байхгүй	50 дугаар зүйл
Байхгүй	51 дүгээр зүйл
2 А дугаар зүйл (2)	52 дугаар зүйлийн 52.1
2 А дугаар зүйл (1)	Байхгүй
2 дугаар зүйл (f)	52 дугаар зүйлийн 52.2
2 дугаар зүйл (d)	52 дугаар зүйлийн 52.3
2 дугаар зүйл (e)	52 дугаар зүйлийн 52.4

Хавсралт 2. Шүүхийн Ерөнхий Зөвлөл “Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн дотоодын болон гадаадын арбитрын ажиллагаанд оролцсон мэдээлэл”

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын
2024 оны 8 дугаар /сарын ... өдрийн
... тоот албан бичгийн хавсралт

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн дотоодын болон гадаадын
арбитрын ажиллагаанд оролцсон шийдвэрийн талаарх мэдээлэл
/2018-2023 он/



Д/д		2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	Нийт
1	Гадаад, дотоодын Арбитрын хэлэлцээрийн биелэлтийг баталгаажуулсан болон татгалзсан	8	3	4	8	5	8	36
2	Талууд тохиролцоогүй тохиолдолд арбитрчийг томилох	0	0	0	0	0	0	0
3	Арбитрчийг татгалзан гаргах	2	1	0	0	1	3	7
4	Арбитрын харьяалал	3	0	1	0	0	1	5
5	Нотлох баримт гаргуулахад туслалцаа хүсэх	2	1	3	4	1	1	12
6	Түр арга хэмжээ авах шийдвэрийг гүйцэтгүүлэх	0	0	1	0	0	0	1
7	Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах	18	28	21	14	14	30	125
8	Шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх хүсэлтийг давж заалдсан нэхэмжлэл	0	0	0	0	0	0	0
	Нийт	33	33	30	26	21	43	186

---o0o---

Хавсралт 3. Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын мэдээлэл

ДОТООДЫН БОЛОН ГАДААДЫН АРБИТРЫН ШИЙДВЭРТЭЙ ГҮЙЦЭТГЭХ БАРИМТ БИЧГИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК МЭДЭЭНД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

Улсын хэмжээнд 2024 оны 6 дугаар сарын байдлаар дотоодын болон гадаадын арбитрын шийдвэртэй нийт 151 гүйцэтгэх баримт бичгийн 599.3 тэрбум төгрөгийг биелүүлэхээс 30 гүйцэтгэх баримт бичгийн 265.8 тэрбум төгрөгийг биелүүлж, 121 гүйцэтгэх баримт бичгийн 333.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, гүйцэтгэх баримт бичгийн биелэлт 19.9 хувь, мөнгөн дүнгийн биелэлт 44.4 хувьтай, өмнөх оны мөн үетэй харьцуулахад гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 3.7 хувиар, мөнгөн дүнгийн биелэлт 43.3 хувиар тус тус өссөн, 7 гүйцэтгэх баримт бичгээр илүү дуусгавар болгосон үзүүлэлттэй ажиллажээ.

Үлдэгдэл гүйцэтгэх баримт бичгийн 27.5 тэрбум төгрөгийн 99 гүйцэтгэх баримт бичиг нь дотоодын, 305.9 тэрбум төгрөгийн 22 гүйцэтгэх баримт бичиг нь гадаадын арбитрын шийдвэртэй байна.

Биелэгдээгүй гүйцэтгэх баримт бичгээс 30.7 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй гүйцэтгэх хуудасны 42 төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 108.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй гүйцэтгэх хуудасны 13 төлбөр төлөгч оршин суугаа хаяг тодорхойгүй, эрэн сурвалжлах ажиллагаа явагдаж байгаа, 116.4 тэрбум төгрөгийн 22 гүйцэтгэх хуудас нь хэсэгчилсэн төлөлттэй, 2.4 тэрбум төгрөгийн 4 гүйцэтгэх хуудас нь дараа жилийн төсөвт тусгагдахаар болсон, 2.2 тэрбум төгрөгийн 7 гүйцэтгэх хуудасны төлбөр төлөгч хилээр гарсан, 73.7 тэрбум төгрөгийн 15 гүйцэтгэх хуудасны хөрөнгөд ажиллагаа хийгдэж байгаа, 2.5 тэрбум төгрөгийн 18 гүйцэтгэх баримт бичиг бусад шалтгаан буюу шүүхээс шинээр ирсэн, ажиллагаа удаашралтай явагдаж байгаа гүйцэтгэх хуудас эзэлж байна.

Улсын хэмжээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдсан гадаад улсын
арбитрын шийдвэрийн тоо (2011-2024)



Хавсралт 4. МҮХАҮТ-ын дэргэдэх Олон улсын арбитраар хянан шийдвэрлэсэн хэргийн мэдээлэл

2020 онд МОУА-т 107 хэрэг шинээр үүссэнээс 8 хэрэг олон улсын шинжтэй байна. Үүнээс:

- Турк-1
- ОХУ-1
- Сингапур-1
- БНСУ-1
- Япон-1

2021 онд МОУА-т 187 хэрэг шинээр үүссэнээс 6 хэрэг олон улсын шинжтэй байна. Үүнээс:

- Малайз-1
- Энэтхэг-1
- Их Британи-1
- ОХУ-1
- БНСУ-1
- БНХАУ-1

2022 онд МОУА-т 200 хэрэг шинээр үүссэнээс 17 хэрэг олон улсын шинжтэй байна. Үүнээс:

- БНХАУ-9
- ОХУ-4
- Япон-1
- БНСУ-1
- Сингапур-1
- Швейцарь-1

2023 онд МОУА-т 185 хэрэг шинээр үүссэнээс 21 хэрэг олон улсын шинжтэй байна. Үүнээс:

- БНХАУ-13
- ОХУ-2
- Энэтхэг-2
- БНСУ-1
- АНУ-1
- Маршаллын арлууд-1
- Сингапур-1

2020, 2021 онуудад цар тахлын нөхцөл байдлын улмаас олон улсын маргааны тоо багассан бол 2022, 2023 онуудад өссөн байна.

ТЭМДЭГЛЭЛ